

Ангилсан, харилцан ажиллах боломжтой эцсийн өмчлөлийн өгөгдөл

Бодлогын товч танилцуулга

2022 оны 9-р сар (2022 оны 8-р сард Англи хэлээр хэвлэгдсэн)

Тойм 2

Ангилсан, харилцан ажиллах боломжтой өгөгдлийн ашиг тус 7

Ашиглалтыг сайжруулах 7

Зардал бууруулна 9

Бодлогын нөлөөг ихэсгэх 13

Эцсийн өмчлөлийн ангилсан өгөгдлийг хэрэглэх нь 17

Таатай орчин бүрдүүлэх 17

Эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулах, хадгалах зарчмыг
тодорхойлох 18

Боломж бололцоогоо ухамсарлаж, хэвлэн нийтлэх үе шатанд тодор-
хойгүй байдлыг арилгах 23

Дүгнэлт 26



Тойм

Өгөгдлийг ангилсан хэлбэрээр авах боломжтой үед эцсийн өмчлөлийн (ЭӨ) өгөгдлийн хэрэглээ, үнэ цэнэ нэмэгддэг. Ангилсан өгөгдөл гэж урьдчилан тодорхойлсон загварын дагуу сайтар ангилагдсан өгөгдлийг хэлнэ. Эхний улс орнууд ЭӨ-ийн өгөгдлийг цуглуулж, зарим нь нийтэлж эхэлснээс хойш зарим нь үүнийг ангилсан өгөгдөл хэлбэрээр хийсэн бол, бусад нь ангилаагүй өгөгдөл хэлбэрээр хийсэн. Ангилаагүй өгөгдөл нь урьдчилан тодорхойлсон өгөгдлийн загварыг дагаж мөрддөггүй. Жишээлбэл: хэрэв эцсийн өмчлөгч болон хуулийн этгээдийн хоорондын харилцааг мэдээлэл өгч буй этгээд өөрийн үгээр тайлбарлах боломжтой бол. Ангилсан өгөгдлийг дижитал бус орчинд үүсгэж болох хэдий ч, ангилсан өгөгдөл нь дижитал хэлбэрээр байгаа үед төхөөрөмжөөр уншуулж, боловсруулахад хялбар байдаг.

Энэхүү бодлогын товч танилцуулгын эхний хэсэгт ЭӨ-ийн ангилсан өгөгдлийг цуглуулах, хадгалах, нийтлэх гол ашиг тусыг тайлбарласан. Нээлттэй, эцсийн өмчлөлийн ангилсан өгөгдлийг нийтэлсэн улс орнууд нь нэмэлт хэрэглэгчдэд илүү өргөн хүрээний өгөгдөлд дүн шинжилгээ хийх боломжийг олгож, эцсийн өмчлөлийн ил тод байдлын (ЭӨИТБ) шинэчлэлийн эхний үр нөлөөг бий болгох ажлыг хялбаршуулсан.¹ ЭӨИТБ-ын шинэчлэлийн үр нөлөөг дээшлүүлэх зорилготой мэдээлэл ил болгох дүрэм нь ЭӨ-ийн мэдээллийг ангилсан өгөгдөл хэлбэрээр цуглуулж, хадгалж, хуваалцах ёстой. Ингэснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- ✓ **ашиглалтыг сайжруулах** (Хуудас 7);
- ✓ **зардлыг бууруулах** (Хуудас 9);
- ✓ **бодлогын нөлөөг ихэсгэх** (Хуудас 13).

Өгөгдлийг ангилснаар урьдчилан таамаглах боломжтой мэдээллийг бий болгоно. Ангилалт нь урьдчилан тодорхойлогдсон тул, хэрэглэгчид өгөгдлөөс юу хүлээж байгаагаа мэддэг ба энэ нь өгөгдөлтэй ажиллахад хялбар болгодог. Эдгээр ашиг тус нь зөвхөн техникийн хэрэглэгчдээр хязгаарлагдахгүй. Техникийн бус хэрэглэгчид өгөгдлийг шууд ашиглахгүйгээр ангилсан өгөгдлөөс ашиг тус хүртэх боломжтой.

Ангилсан өгөгдлийг вэб интерфэйс, аппликейшн програмчлалын интерфэйс (API) гэх мэт төхөөрөмж, компьютер, вэбсайт, програм болон бусад хэрэгслээр урьдчилан боловсруулсан хэлбэрээр эсвэл бөөнд нь боловсруулах хэлбэрээр ашиглах боломжтой тул, хүмүүс холбогдох мэдээлэлд техникийн бус янз бүрийн аргаар нэвтрэх, дүрслэх, харилцах боломжтой байхаар хөгжүүлж болно. Ангилсан өгөгдлийг хүн болон төхөөрөмжөөр хийх үйл ажиллагаанд аль алинд нь нэгтгэх боломжтой бөгөөд энэ нь ангилаагүй өгөгдлийн хувьд боломжгүй буюу их ажиллагаатай байдаг. Жишээ нь, ангилсан ЭӨ-ийн өгөгдлийг бөөнд нь боловсруулах хэлбэрээр хуваалцсанаар Санхүүгийн мэдээллийн алба, худалдан авах агентлаг, банк, сэтгүүлч зэрэг хэрэглэгчдэд ашиг сонирхлын бусад багц өгөгдөл дээр харагдсан сэжигтэй өмчлөлийн хэлбэр эсвэл эцсийн өмчлөгчийг тодорхойлох зорилгоор өгөгдлийн судалгаа, төхөөрөмжөөр судлах арга техникийг хэрэглэх боломжийг олгоно.

Ангилаагүй өгөгдөлтэй холбоотой саад тотгорыг арилгаснаар, ангилсан өгөгдөл нь засгийн газрын өгөгдөл цуглуулах зардлыг бууруулж, хуулийн этгээдийн ил тод зарлах шаардлагад нийцнэ. Энэ нь өгөгдлийг хадгалах, нийтлэхтэй холбоотой зардлыг мөн бууруулна. Ангилсан өгөгдөл нь ашиглалт, дүн шинжилгээ хийхтэй холбоотой зардлыг бууруулах замаар ЭӨИТБ-ын шинэчлэлийн бодлогын зорилтуудыг биелүүлэх зардлыг бууруулж, нөлөөг ихэсгэнэ. Шаардлагатай системийг бий болгохтой холбоотой өндөр өртөг зардлыг урт хугацаанд цуглуулах, хадгалах, нийтлэх, ашиглах, засварлахтай холбоотой бага зардлаар нөхнө гэж үзэж байгаа.

Ангилсан өгөгдөл нь харилцан ажиллах боломжтой буюу өгөгдлийг бусад эх сурвалжийн хамтаар ашиглахад хялбар бөгөөд өөр систем, процесст нэгтгэх боломжтой юм. ЭӨ-ийн нарийн төвөгтэй харилцааны үндэстэн дамнасан шинж чанар нь өмчлөлийн бүтцийг бүрэн ил тод болгохын тулд өөр өөр улс орнуудын ЭӨ-ийн багц өгөгдлийг нэгтгэх зайлшгүй шаардлагатай болгодог. Худалдан авалтын үйл ажиллагааг сайжруулах,



хориг арга хэмжээ, кампанит ажлын санхүүжилтийн зохицуулалтыг хэрэгжүүлэх зэргээр ЭӨИТБ-ыг хэрэгжүүлж буй улс орнууд бодлогын нэмэлт зорилтуудыг биелүүлэхийн тулд мэдээллийг бусад багц өгөгдөлтэй хослуулах шаардлагатай болдог. ЭӨ-ийн өгөгдөл нь ангилсан, харилцан ажиллах боломжтой үед илүү өргөн хүрээний баталгаажуулалтын механизмыг ашиглах боломжтой тул, баталгаажуулахад хялбар ба улмаар өгөгдлийн чанар сайжирдаг.

Open Ownership (ОО) байгууллагын Эцсийн өмчлөлийн өгөгдлийн стандарт (ЭӨӨС) зэрэг өгөгдлийн стандартыг өргөнөөр нэвтрүүлснээр эдгээр ашиг тусыг дээд зэргээр хүртэх боломжтой.^a ЭӨӨС нь дэлхий даяарх компьютерийн системүүд уншиж, ойлгохуйц форматаар эцсийн өмчлөлийн тухай ангилсан өгөгдлийг нийтлэх тогтолцоо юм. ЭӨӨС-ыг засгийн газар болон хувийн хэвшлийн аль алиных нь хамт баталж, энэ хүрээнд хэд хэдэн хэрэгсэл, програмыг хөгжүүлсэн.²

Энэхүү бодлогын товч танилцуулгын хоёрдугаар хэсэгт ЭӨ-ийн ангилсан өгөгдлийг ашиглахад хэрэгжүүлэгчдэд юу хэрэгтэйг онцолсон. ЭӨ-ийн ангилсан өгөгдлийг ашиглахын тулд хэрэгжүүлэгчид дараахыг хийнэ. Үүнд:

- Хэрэглэгч төвтэй, интерактив аргыг ашиглан, ЭӨИТБ-тай холбоотой техникийн зорилтуудад хүрэхийн тулд хууль эрх зүй, зохицуулалт, бодлогын тогтолцоог бий болгож, үе шаттайгаар сайжруулах замаар таатай орчныг (Хуудас 17) бүрдүүлэх. Үүнд Open Ownership байгууллагын зарчимд (ОО-ын зарчим) нийцсэн хууль эрх зүйн болон бодлогын хатуу тогтолцоог бүрдүүлэх, хангалттай нөөцөөр хангах зэрэг орно.^b
- ЭӨ-ийн өгөгдлийг цуглуулах, хадгалах зарчмыг бий болгох (Хуудас 18), наанадаж ЭӨ-ийн ангилсан өгөгдлөөр хангах:
 1. Онцгой таних тэмдэг болон хангалттай тайлбарлах талбаруудыг ашиглан ЭӨ-ийн мэдүүлэгт ил болгосон хүмүүс, компаниуд болон бусад холбогдох талуудыг тодорхойлох;
 2. ЭӨ-ийн мэдэгдэлд ил болгосон талуудын хооронд байж болох бүх харилцааг тодорхойлох;
 3. ЭӨ-ийг мэдээлэх байдалд аудит хийх боломж олгох.

Хэрэгжүүлэгчид нь системийн загвар, бизнесийн үйл ажиллагааг (Хуудас 22) техникийн түвшний шинэчлэлийн зорилтуудтай нийцүүлэх ёстой. Техникийн систем, өгөгдлийн сангийн загвар нь хэвлэн нийтлэх, өгөгдөл солилцох үе шатанд хүлээгдэж буй бүрэн ажиллагаа, нэвтрэх эрхтэй нийцэж байгаа эсэхийг хэрэгжүүлэлтийн эхний үе шатанд анхаарвал зохино.^c

- Боломж бололцоогоо ухамсарлаж, хэвлэн нийтлэх үе шатанд тодорхойгүй байдлыг арилгана (Хуудас 23). Нийтлэгдсэн өгөгдлийг хэрэглэгчид аудит хийх боломжтой байлгах нь өгөгдлийн бүрэн боломж бололцоог хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Нийтлэгдсэн өгөгдлийг техникийн бус хэрэглэгчид, техникийн хэрэглэгчид, системүүдийн аль алинд нь янз бүрийн аргаар ашиглах боломжтой болгох замаар үүнд хүрч болно. Тухайлбал:

- вэб интерфэйсээр дамжуулан бүртгэлээр хайх;
- вэб интерфэйсээр дамжуулан бүртгэл үзэх;
- бөөнд нь боловсруулах хэлбэр;
- API-ээр дамжуулан нэвтрэх.

Хэрэгжүүлэгчид мөн өгөгдлийн зохих лицензийг шийдвэрлэж, нийтэлсэн өгөгдөлтэй холбоотой тодорхой бус байдлыг арилгах ёстой нийтлэх бодлогын хэлбэрээр хангалттай баримт бичгийг өгвөл зохино.

Ангилсан өгөгдөл нь өгөгдлийг бусад өгөгдөлтэй амархан нэгтгэж, урьдчилан таамаглах боломжтой, найдвартай болгодог тул ОО-ын зарчмын үндсэн ойлголт юм.³ ОО-ын зарчим нь ЭӨ-ийг үр дүнтэй ил болгох стандартыг тогтоож, өндөр чанартай, хэрэгцээтэй өгөгдлийг хэвлэн нийтлэх арга барилыг тодорхойлдог. ОО-ын зарчим нь нийтлэгдсэн өгөгдлийг хэрэгцээтэй, алдаа мадаггүй, харилцан ажиллах боломжтой байлгахад тусалдаг.


^a Нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: "Beneficial Ownership Data Standard (v0.3)", Open Ownership, n.d., <https://standard.openownership.org>.

^b Нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: "Open Ownership Principles", Open Ownership, updated July 2021, <https://www.openownership.org/en/principles>.

^c Өгөгдлийн сангийн загварын талаар нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: "Relational database design considerations for beneficial ownership information", Extractive Industries Transparency Initiative and Open Ownership, 16 December 2021, <https://www.openownership.org/en/publications/relational-database-design-considerations-for-beneficial-ownership-information>.



Зураг 1. Ангилсан өгөгдлийг ашиглан эцсийн өмчлөлийг ил тод болгох системийн жишээ



Ангилсан ЭӨ-ийн өгөгдөл нь түүний ажиллагааг сайжруулж (Хуудас 7), бүх үе шатанд зардлыг бууруулж (Хуудас 9), бодлогын нөлөөг ихэсгэхэд хүргэдэг (Хуудас 13). Үүнд хүрэхийн тулд, хэрэгжүүлэгчид таатай орчныг бүрдүүлэх ёстой (Хуудас 17) бөгөөд өгөгдөл нь эцсийн өмчлөлийн гол элементүүдийг тодорхойлох, тайлбарлах байдлаар ангилагдсан байх ёстой (Хуудас 18). ЭӨ-ийн өгөгдлийг цуглуулах, хадгалах, засварлах, солилцох, нийтлэх (Хуудас 22) боломжтой байхын тулд, дижитал системүүд болон удирдлагын процессууд хоорондоо жигд нийцэж байх шаардлагатай. Нээлттэй стандартыг дагаж мөрдөх (Хуудас 23), мөн баримт бичиг, лицензийн мэдээллийг (Хуудас 24) багтаасан хэвлэлийн тодорхой бодлогыг нийтлэх замаар хуваалцах, нийтлэх үе шатанд тодорхойгүй байдлыг шийдвэрлэх хэрэгтэй. Өгөгдөлд нэвтрэх олон арга замаар өгөгдлийг аудит хийх боломжтой болгож болно (Хуудас 24). ЭӨӨС зэрэг өгөгдлийн стандартууд нь ангилсан өгөгдлийн форматын хамтаар ЭӨ-ийн өгөгдлийг (Хуудас 23) цуглуулах, хуваалцах, ашиглах удирдамжаар хангана.

Нүд 1: Гол ойлголт, тодорхойлолт

Ангилсан, харилцан ажиллах боломжтой ЭӨ-ийн өгөгдөл нь бодлогын зорилтууд болон ангилсан ЭӨ-ийн өгөгдлийг цуглуулах, хадгалах, хуваалцахад шаардлагатай бодлогыг хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж болохыг ойлгохын тулд, хэд хэдэн гол ойлголтыг тайлбарлах зайлшгүй шаардлагатай. Эдгээр ойлголтуудын зарим нь илүү ерөнхий хүрээнд үйлчлэх хэдий ч, ЭӨ-ийн өгөгдлийн нөхцөл байдалд голчлон анхаардаг.

Өгөгдөл нь төхөөрөмж болон хүмүүс мэдээллийг хадгалах, дамжуулахад ашиглагдана. Энэ нь мэдээллийн нэгж юм. Өгөгдөл нь өөрөө ямар ч утгагүй хэдий ч, тодорхой нөхцөлд ашиглах эсвэл харах үед утгатай болдог.

Ангилсан өгөгдөл гэж урьдчилан тодорхойлсон загварын дагуу сайтар ангилагдсан өгөгдлийг хэлнэ.^d Энэ нь төхөөрөмжөөр тайлбарлаж, эцсийн өмчлөлийн утга учиртай мэдээллийг дамжуулахад хангалттай агуулга, ангилал, нөхцөлтэй (Хүснэгт 1 харна уу). Ангилсан өгөгдлийг дижитал бус орчинд үүсгэж болох хэдий ч, уг товч танилцуулгад энэ нь дижитал өгөгдөлд хамаарна.

Төхөөрөмжөөр унших боломжтой өгөгдөл нь төхөөрөмж эсвэл компьютероор хялбар боловсруулж болох формат бүхий өгөгдөл юм. Төхөөрөмжөөр унших боломжтой өгөгдөл нь дижитал ангилсан өгөгдөл байх ёстой.

Өгөгдлийг бусад өгөгдлийн эх сурвалжтай хялбар ашиглаж, янз бүрийн систем, процесст нэгтгэж болж байвал **харилцан ажиллах боломжтой**. Харилцан ажиллах боломжтой ЭӨ-ийн өгөгдлийн хувьд, жишээ нь, компанийн дугаарыг тайлбарлах нийтлэг аргыг ашиглаж, өөр өөр улс орнуудын багц өгөгдлийг нэгтгэх боломж олгодог.⁴ Харилцан ажиллах боломжтой ЭӨ-ийн өгөгдлийг гэрээний өгөгдөл гэх мэт ЭӨ-ийн бус багц өгөгдөлтэй нэгтгэж болно.

Өгөгдлийн стандарт нь өгөгдлийг хэрхэн ангилах, хэвлэн нийтлэх, нөхцөл байдалтай уялдуулах талаарх дүрэм, гэрээний баримтжуулсан иж бүрдлээр хангана. Өгөгдлийн хэлбэр, тодорхойлолт, дамжуулалт, зохицуулалт, ашиглалт, удирдлагыг мөн хамарч болно. Стандартууд нь гарал үүслээс үл хамааран өгөгдлийг үүсгэх, ойлгох нийтлэг хэлээр хангах бөгөөд загварын хувьд дээд зэргээр харилцан ажиллах боломжийг олгоно. Нэг өгөгдлийн стандартад нийцэхгүй ангилсан өгөгдөл нь харилцан ажиллах боломжтой (гэхдээ заавал ингэх шаардлагагүй) байж болох хэдий ч, өгөгдлийг нэгтгэхийн тулд нэмэлт хувиргалт хийх шаардлага гарч болно. Доор илүү дэлгэрэнгүй авч үзэх ЭӨӨС нь өндөр чанартай ЭӨ-ийн өгөгдлийн дүрмийг тогтоодог өгөгдлийн стандарт юм.⁵

^d Албан ёсоор бол, “ангилсан”, “хагас ангилсан” өгөгдөл нь өөр өөр ангилалд орно. Гэлээ ч, ЭӨИТБ-ын зориулалтаар, нэг ижил мэдээлэл нь ихэвчлэн ангилсан хэлбэрээр (харилцаа холбооны өгөгдлийн санд) **хадгалагдаж**, хагас ангилсан хэлбэрээр (JavaScript Object Notation (JSON) эсвэл XML гэх мэт) **нийтлэгддэг** гэдгийг мэдэж байх хэрэгтэй. Ангилал, нөхцөл байдалтай нь уялдуулж хангалттай мэдээллийг дамжуулж л байвал, ангилсан болон хагас ангилсан өгөгдлийг аль алиныг нь энэхүү товч танилцуулгад ашигласан тодорхойлолтод оруулсан.



Хүснэгт 1. Ангилаагүй (зүүн) болон ангилсан (баруун) эцсийн өмчлөлийн өгөгдөл

Өмчлөл буюу хяналтын шинж чанар

Энэхүү эцсийн өмчлөгч нь мэдүүлэгч хуулийн этгээдийн хувьцааг дараах хувьцаа эзэмшигчидээр дамжуулан мэдүүлж буй хуулийн этгээдийн нийт хувьцааны 27 хувийг шууд бусаар буюу үр хүүхдүүдээрээ дамжуулан эзэмшдэг: (1) “Angerujjheit BV” Нидерланд улс дахь бүртгэлийн дугаар: 64739564, бүртгэлтэй хаяг: Byterslaan 105, NL-4722GF Amsterdam, Netherlands; (2) “RigaTech Systems Ltd.” Британийн Виржиний Арлууд дахь бүртгэлийн дугаар: 396654, бүртгэлтэй хаяг: P.O. Box 124, Offshore Incorporations Centre, Road Town, Tortola, British Virgin Islands

Өмчлөл буюу хяналтын шинж чанар

Нийт хувьцааны өмчлөлийн %	27
Саналын эрхтэй хувьцаагаар дамжуулах нийт хяналтын %	27
Мэдүүлэгч хуулийн этгээд дэх хувьцааны шууд эзэмшил	0
Мэдүүлэгч хуулийн этгээд дээр шууд санал өгөх хяналтын эрх	0

1.1 Завсрын хууль ёсны эзэмшигч нар

Хууль ёсны эзэмшигч 1

Нэр	Angerujjheit B.V.
Бүртгэлийн байгууллага	Нидерландын худалдааны бүртгэл
Бүртгэлийн дугаар	64739564

Хууль ёсны эзэмшигч 2

Нэр	RigaTech Systems Ltd.
Бүртгэлийн байгууллага	Их Британийн Виржиний Арлуудын Компанийн бүртгэлийн газар
Бүртгэлийн дугаар	396654

Энэхүү хийсвэр жишээний зүүн талд эцсийн өмчлөгч болон түүний компанитай харилцах харилцаатай холбоотой бүх мэдээлэл нэг бичвэрийн талбарт байгаа тул, өгөгдөл нь ангилагдаагүй байна. Баруун талд өгөгдөл нь янз бүрийн талбаруудад стандартчилагдсан байдлаар хуваагдсан байгаа тул, өгөгдөл нь ангилагдсан байна.



Ангилсан, харилцан ажиллах боломжтой өгөгдлийн ашиг тус

ЭӨ-ийн өгөгдлийг ангилсан өгөгдлийн хэлбэрээр цуглуулах, хадгалах, хангах нь мэдээллийн ашиглалтын хувьд олон давуу талтай. Өргөн утгаараа энэ нь:

- ЭӨ-ийн мэдээллийн ашиглалтыг сайжруулна;
- ЭӨ-ийн мэдээллийг үүсгэх, ашиглах, хадгалах зардлыг бууруулна;
- ЭӨИТБ-ын бодлогын зорилтуудад хүрэх магадлал нь ангилаагүй өгөгдлөөс хавьгүй илүү байна.

Ашиглалтыг сайжруулах

Нүд 2: Open Ownership байгууллагын бүртгэлээс эцсийн өмчлөлийн өгөгдлийг хайх, судлах

Open Ownership байгууллагын бүртгэл (ОО-ын бүртгэл) нь эцсийн өмчлөгч, хуулийн этгээдийг хайж олох, олон бүртгэлийн ЭӨ-ийн өгөгдлийг нэгтгэх замаар улс орнуудын өмчлөлийн харилцаа холбоог судлах боломжийг хүмүүст олгоно.^e Суурилуулсан хэрэгслүүдийн тусламжтайгаар өмчлөгчдийн бүтцийг дүрслэн харуулах, хувь хүн, хуулийн этгээдийн өгөгдлийг татаж авах боломжтой.

Үүнийг хийхэд хэрэглэгчид техникийн мэдлэгтэй байх шаардлагагүй. ОО-ын бүртгэл нь ЭӨ-ийн мэдээллийг ангилсан өгөгдлийн хэлбэрээр нийтэлдэг олон улс орнуудын өгөгдлийн эх сурвалжийг ашиглан ийм функцээр хангадаг.

Өгөгдөл нь ангилагдсан байдаг тул, ОО-ын бүртгэл нь зарим улс орнуудын өөрсдийнх нь онлайн порталд байдаггүй функцээр хангах боломжтой. Жишээ нь, ОО-ын бүртгэлийн ЭӨ-ийн өгөгдөл авдаг улс орнуудын нэг нь Их Британи улс юм. Их Британийн ЭӨ-ийн бүртгэлээс компанийн нэр, компанийн дугаар, албан тушаалтнуудын нэрийг хайж болох хэдий ч, эцсийн өмчлөгчийг хайх боломжгүй. Харин ОО-ын бүртгэл дээрээс Их Британиас бусад улс орнуудын өгөгдлийн хамтаар эцсийн өмчлөгчдийн нэрээр хайх боломжтой.

^e ОО-ын бүртгэл нь үндэсний дөрвөн ЭӨ-ийн бүртгэлийн өгөгдлийг хүлээж авдаг. Үүнийг харна уу: “Open Ownership Register – Data Sources”, Open Ownership, n.d., https://register.openownership.org/data_sources.



Өгөгдлийг ангилснаар урьдчилан таамаглах боломжтой мэдээллийг бий болгоно: ангилал нь урьдчилан тодорхойлогдсон тул, хэрэглэгчид өгөгдлөөс юу хүлээж байгаагаа мэддэг. Ингэснээр ажиллахад хялбар болно. Техникийн бус хэрэглэгчид өгөгдлийг шууд ашиглахгүйгээр ангилсан өгөгдлөөс ашиг тус хүртэх боломжтой. Вэбсайт, програм болон бусад хэрэгслээр дамжуулан хүмүүс холбогдох мэдээлэлд техникийн бус янз бүрийн аргаар нэвтрэх, дүрслэх, харилцах боломжтой. Ангилсан өгөгдлийг хүн болон төхөөрөмжөөр хийх үйл ажиллагаанд аль алинд нь нэгтгэх боломжтой бөгөөд энэ нь ангилаагүй өгөгдлийн хувьд боломжгүй буюу их ажиллагаатай байдаг. Үүнд:

- Мэдэгдэж буй хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой бүртгэл хайх, эсвэл тодорхой шалгуурт (жишээ нь, хаяг эсвэл иргэний харьяалал) тохирох үл мэдэгдэх хүмүүсийг хайх зорилгоор ЭӨ-ийн өгөгдлийг хайх, лавлах (Нүд 2 харна уу);

- Эцсийн өмчлөлтэй холбоотой хэлбэр, нягтлах шаардлагатай мэдээллийг хайх, эсвэл өгөгдлийн чанарыг үнэлэх, сайжруулах зорилгоор дан эсвэл хосолсон багц өгөгдөлд бөөнд нь дүн шинжилгээ хийх (Нүд 3 харна уу);
- Компанийн өмчлөгчийн мэдээлэлтэй холбоотой бизнесийн үйл явцыг автоматжуулах (жишээ нь, нийлүүлэгчийг бүртгэх, үйлчлүүлэгчийг шалгах) (Нүд 4 харна уу);
- Нарийн төвөгтэй мэдээллийг тухайн нөхцөл байдал болон хэрэглэгчдэд тохирсон хэрэглэгчдэд ээлтэй хэлбэртэй болгож хувиргах (жишээ нь, дүрсжүүлэлт эсвэл нэгтгэсэн хүснэгт) (Нүд 5 харна уу).

Өгөгдлийн стандарт нь энэхүү дэвшилтэт функцийг ашиг тусыг бүрэн дүүрэн хүртэх байдлыг хялбаршуулдаг. Учир нь ЭӨ-ийн өгөгдөл нь гарал үүслээс үл хамааран урьдчилан таамаглах боломжтой тул, олон байгууллагуудын хооронд өгөгдөл дээр хамтарч ажиллах, ашиглахад хялбар болгодог.

Нүд 3: Их Британийн эцсийн өмчлөлийн өгөгдөлд бөөнд нь хийсэн дүн шинжилгээ

2016 онд Их Британи нь компаниудын эцсийн өмчлөгчдийн олон нийтийн бүртгэлийг бий болгосон анхны орнуудын нэг болсон. Их Британийн бүртгэлийг Нөлөө бүхий эзэмшигчдийн бүртгэл (PSC) гэж нэрлэдэг бөгөөд салбартаа түүчээлсэн. Ингэхдээ нээлттэй, ангилсан өгөгдлийг нийтэлсэн нь бусдад их хэмжээний өгөгдөлд дүн шинжилгээ хийх боломж олгосон. 2016 оны 11-р сард төрийн бус байгууллагуудын консорциумаас бөөнд нь дүн шинжилгээ хийсэн.⁶ Уг дүн шинжилгээгээр Их Британийн бүртгэлийг сайжруулахад мөн бусад улс орнуудад олон нийтийн ЭӨ-ийн бүртгэлийг хэрхэн бий болгох талаар маш их зүйлийг сурч авсан.

Шинжилгээгээр өгөгдлийн чанарт хэд хэдэн асуудал илрүүлсэн. Жишээ нь, холбогдох талбарт иргэний харьяаллаа бичиж оруулахыг зөвшөөрснөөр “Британи” гэж 500 гаруй удаа бичигдсэн бол 10 эцсийн өмчлөгч өөрийн иргэний харьяаллыг Корнуолл (Английн нэг муж) гэж бичсэн болохыг харуулсан.⁷ Мөн дүн шинжилгээгээр 2,160 эцсийн өмчлөгч өөрийн төрсөн оноо 2016 он гэж оруулсан бол зарим нь 9988 онд төрсөн гэж мэдээлсэн байсан.

2016 оны өгөгдлийн дүн шинжилгээний үр дүн гарсны дараа, Companies House (CH)-аас хэрэглэгчид 16-аас доош буюу 100-аас дээш насны төрсөн огноог оруулах, хүмүүсийг 110-аас дээш настай гэж мэдээлэл оруулахгүй байх тухай анхааруулгыг PSC бүртгэлд оруулсан.⁸

Үүний нэг адилаар, 2017 онд Transparency International болон Bellingscat байгууллагаас ил тод зарлах шаардлагад анх ороогүй байсан Шотландын Хязгаарлагдмал Хариуцлагатай Нөхөрлөлүүдэд (SLP) томоохон хэмжээний шалгалт хийсэн. Тэд 2016 онд бүртгэгдсэн бүх SLP-ийн 71% нь эзэмшлийн нууцлалын эрх зүйн зохицуулалттай улс орнуудад байрлах компаниудын эзэмшилд байсныг олж тогтоосон.⁹ Энэхүү дүн шинжилгээг SLP-тэй¹⁰ холбоотой өргөн хэмжээний зөрчлийн тайлантай хослуулан Их Британи улс SLP-ийг ил тод зарлах шаардлагынхаа хамрах хүрээнд оруулахад хүргэсэн. Дараагийн удаагийн бөөнд нь хийсэн дүн шинжилгээгээр SLP-ийн бүртгэл буурсан нь ил тод байдлыг бууруулах нөлөөтэй байгааг харуулж байна.¹¹



Нүд 4: YouControl: Украин дахь үйлчлүүлэгчийг шалгахын тулд эцсийн өмчлөлийн ангилсан өгөгдлийг бусад өгөгдлийн эх сурвалжтай хослуулах¹²

YouControl бол бизнесийн ил тод байдлыг эрхэмлэдэг Украин компани бөгөөд “хууль дүрмийн хэрэгжилт, зах зээлийн шинжилгээ, бизнесийн судалгаа, шалгалтын дүн шинжилгээ хийх системийг” боловсруулсан.¹³ YouControl нь Украины ЭӨ-ийн бүртгэлийн ангилсан өгөгдөл зэрэг 180 эх сурвалжаас авсан нэгтгэсэн өгөгдлийг өөрт байгаа эцсийн өмчлөгчийн дүн шинжилгээтэй нэгтгэх замаар төлөгдөөгүй татвар, хүлээгдэж буй шүүх хурал, татварын тайлангаа хугацаанд нь амжиж мэдүүлж чадаагүй гэх мэт нягтлах шаардлагатай чухал мэдээллийг багтаасан ихээхэн хэмжээний мэдээллийн хамтаар компанийн танилцуулгыг гаргаж өгдөг. Энэ нь санхүүгийн тогтвортой байдал болон хуурамч байршлаас үйл ажиллагаа явуулж буй компанийн эрсдэлийг тооцоолоход өөрийн алгоритмуудыг ашигладаг.

Вэбсайт дээрх хэд хэдэн кейс судалгаануудаас харахад олон компаниуд сайн мэдэхгүй байгууллагуудтай бизнес хийхээсээ өмнө залилангийн бизнесийг илрүүлэх зорилгоор YouControl-ийг ашиглан хэдэн зуун мянган доллар хэмнэсэн байдаг.¹⁴

Зардал бууруулна

Харилцан ажиллах боломжтой ЭӨ-ийн ангилсан өгөгдөл нь ангилаагүй өгөгдлийг бодвол нийт ашиглалтын хугацааны зардалд ихээхэн давуу талтай бөгөөд дараах зардлуудыг бууруулна. Үүнд:

- ЭӨ-ийн өгөгдлийг нийтлэх, засварлах, шинэчлэх;
- ЭӨ-ийн өгөгдлийг ашиглах;
- бодлогын үр ашгийг бодит болгох;
- ил тод зарлах шаардлагад нийцүүлэх.

Эцсийн өмчлөлийн өгөгдлийг нийтлэх, засварлах, шинэчлэх

ЭӨ-ийн өгөгдлийг ангилах шийдвэр нь ихэвчлэн өндөр өртөг зардалтай байдаг бөгөөд энэ нь урт хугацаандаа ашиглалтын зардал багатай байснаар нөхөгддөг. Өгөгдлийг ангилснаар баримтжуулах, далд тодорхойгүй байдлыг арилгахыг шаарддаг. Баримтжуулалт нь өгөгдлийн ангилал, түүний агуулгыг тайлбарлах замаар аливаа хэрэглэгчдэд ойлгомжтой, тайлбарлах

боломжтой байлгадаг. Жишээ нь, баримтжуулалт нь огнооны талбарыг тодорхой хэлбэрт оруулж болно. Жишээ нь, Олон улсын стандартчиллын байгууллагын (ISO) 8601 огнооны форматыг ашигласан (ОООО-СС-ӨӨ) тул, 2022-07-11 нь 2022 оны 11-р сарын 7 биш, харин 2022 оны 7-р сарын 11 гэдэг нь тодорхой болно.¹⁵

Хоёрдмол утгагүй баримтжуулалт нь тогтмол засварлах зардлыг бууруулж, өгөгдөл ашиглахтай холбоотой саад тотгорыг бууруулдаг. Энэ нь өгөгдлийг шинэчлэх үйл явцын хүрээнд хийгдэх өгөгдлийн ангиллыг өөрчлөх шаардлагатай үед мөн хэрэглэгдэнэ. Ангилсан өгөгдлийн урьдчилан таамаглах боломжтой байдал нь тогтмол зардлыг илүү нарийвчлалтай хуваарилахаас гадна өгөгдөл, бизнесийн үйл ажиллагааны шинэчлэлтийг тодорхой төлөвлөж, баримтжуулах боломж олгодог.¹⁶ Хэрэв өгөгдлийн стандартын дагуу өгөгдлийг нийтэлсэн бол, хэрэгжүүлэлтийн шатны олон нарийн төвөгтэй байдлыг аль хэдийн харгалзан үзэх тул, анхны хөгжүүлэлтийн зардлыг бууруулдаг. Нийтлэгдсэн өгөгдөл нь одоо байгаа баримтжуулалт, техникийн хэрэгслүүдээс мөн ашиг тус хүртэнэ.

Жишээ нь, уг ажлыг эхэлж хэрэгжүүлсэн орнуудын нэг болох Словак улсад тогтсон арга барилаас сургамж авах боломж байгаагүйн улмаас, “шинэ бүртгэл үүсгэхэд ойролцоогоор 330,000 евро зарцуулсан”, “жилийн үйл ажиллагааны зардал нь ойролцоогоор 33,000 евро” гэж тооцдог.¹⁷ Үүнтэй адилаар, Европын Холбоонд хийсэн судалгаагаар Гишүүн орнууддаа ЭӨ-ийн өгөгдлийг ангилсан өгөгдөл болгох боломж олгох үйл ажиллагааны зардлыг жилд 50,000 евро буюу 4-10 ажилтан бүтэн цагаар ажиллана гэж тооцсон.¹⁸ Эдгээр зардлыг нөхцөл байдалтай нь уялдуулан авч үзвэл, Их Британид хэрэгжүүлсний дараах хэрэглэгчийн үр ашгийн үнэлгээ нь “СН-ын өгөгдөл хэрэглэгчийн жилийн ашиг тус нь жилд нийтдээ 1-3 тэрбум фунт стерлингийн хооронд хэлбэлздэг гэж дүгнэсэн. Энэ нь зөвхөн Companies House Service (CHS)-ийн хэрэглэгчдийн хүртэж буй ашиг тусыг багтаасан тул дутуу тооцогдсон байх магадлалтай.” Ангилсан өгөгдөл хэлбэрээр мэдээллийг нийтэлснээр үзэх боломжтой болсон өгөгдөлд нэвтрэх янз бүрийн хэлбэрүүд нь хэрэглэгчдэд хамгийн их үнэ цэнийг бий болгож байна гэж онцолсон.¹⁹

Эцсийн өмчлөлийн өгөгдлийг ашиглах

Ангилсан ЭӨ-ийн өгөгдлийг төрийн болон хувийн хэвшлийнхэн ашиглахад илүү шуурхай, хямд байдаг тул, чухал өгөгдөлд нэвтрэх зардлыг бууруулах, ЭӨ-ийн мэдээллийг бусад багц өгөгдөл, системүүдтэй холбох боломжтой. Жишээ нь, хууль сахиулах байгууллагын ангилаагүй мэдээлэлд нэвтрэх зардал нь Канад улсад ЭӨИТБ-ыг нэмэгдүүлж буй чухал шалтгаан гэж онцолсон.²⁰ Ангилсан ЭӨ-ийн өгөгдөл байгаа тохиолдолд,



дотоодэсвэлгадныбайгууллагынбүртгэл,зохихшалгалт эсвэл зохицуулалтын технологийн үйлчилгээнд үүнийг хялбархан нэгтгэж болно. Санхүүгийн байгууллагуудын ЭӨ-ийн өгөгдлийг ашиглах талаар ОО-ын хийсэн судалгаагаар ЭӨ-ийн мэдээллийг нээлттэй, ангилсан өгөгдөл болгон ашиглах боломжтой болгосон улс орнуудтай харьцуулахад, нэг улсын нэг банк ангилаагүй PDF хэлбэртэй ЭӨ-ийн тайланг боловсруулах зардлыг “хяналт бүрд нэмэлт 7 евро” гэж тооцсон байна. Банк жилд олон мянган хяналт хийдэг учраас энэ нь “банкны хувьд том зардал” гэдгийг онцолсон.²¹

Бодлогын үр ашгийг бодит болгох

Ангилсан ЭӨ-ийн өгөгдлийг харилцан ажиллах боломжтой болсноор бодлогын үр ашгийг бодит болгох зардлыг мөн бууруулж чадна. Жишээ нь, өгөгдөл нь ижил өгөгдлийн стандартын дагуу ангилагдсан тохиолдолд, өөр өөр системүүд хоорондоо харилцах боломжтой нийтлэг хэлийг ашиглах боломжтой болгож, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх зардлыг бууруулж чадна. Түүнчлэн, эдгээр бодлогын зорилтууд нь эдийн засгийн үр ашиг бий болгох боломжтой.²² Эдгээр үр

ашиг нь ихэвчлэн хэрэгжүүлэгч агентлагаас гаднаас орж ирдэг тул, өгөгдлийн ангилал, төсөвлөлтийн зардал, үр ашгийг үнэлэх цогц арга барилыг шаарддаг.²³

Ангилсан өгөгдөл нь харилцан ажиллах боломжийг хэд хэдэн аргаар хялбаршуулдаг. Юун түрүүнд, **харилцан ажиллах техникийн боломж**: жишээ нь, ЭӨ-ийн өгөгдлийг нийтлэх өгөгдлийн стандартыг ашиглах нь нэг нөхцөл байдалд бий болгосон хэрэгсэл, дүн шинжилгээг нөгөөд дахин ашиглах боломжийг олгож, хөгжүүлэлтийн зардал, цаг хугацааг багасгадаг. Өгөгдлийг ЭӨӨС-д нийтэлснээр Армени улс ОО-ын ЭӨӨС-ын дүрсжүүлэлтийн санг ашиглан өмчлөлийн схемийг автоматаар үүсгэх боломжтой болсон бөгөөд ингэснээр өөрийн бүртгэлийн эхний хувилбарт дэвшилтэт функцүүдийг шуурхай нэвтрүүлсэн (Нүд 5 харна уу).²⁴ Үүнтэй нэг адилаар, эцсийн өмчлөлийн болон худалдан авалтын өгөгдлийг холбох загвар хэрэгсэл болох Bluetail нь хэд хэдэн хэл дээр байдаг бөгөөд Индонези, Кени, Өмнөд Африкт хэрэглэгддэг (Зураг 3 харна уу).²⁵

Нүд 5: Армени улсын эцсийн өмчлөлийн өгөгдлийг ангилах нь

Армени улс ЭӨ-ийн төвлөрсөн бүртгэлийг хэрэгжүүлэхдээ ЭӨ-ийн ангилаагүй өгөгдлийг цуглуулж, нийтэлж байснаа больж, засгийн газар болон бусад газарт ашиглах зорилгоор ЭӨӨС-ын дагуу ангилсан өгөгдлийг нийтлэх хувилбар руу шилжсэн.

Армени дахь ажиллагаа нь тус улсын олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын ЭӨ-ийн мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлагыг туршилтаар хэрэгжүүлснээр эхэлсэн. 2023 оны эцэс гэхэд эдийн засгийн бүх салбар дахь компаниудад тавигдах шаардлагыг аажмаар өргөжүүлэхээс өмнө эрсдэл өндөртэй салбараас өгөгдөл цуглуулах, нийтлэх системийг хөгжүүлж, туршихад уг туршилтын хөтөлбөрийг ашигласан.

Армени улс 2020 онд хэрэгжүүлэх туршилтын төслийн өгөгдөл цуглуулах, гаргах ажлыг хурдасгахын тулд, бүртгэлийн програм хангамжаа шинэчилж дуусгахын зэрэгцээ завсрын алхам болгож цаасан маягтыг ашиглан ЭӨ-ийн мэдээллийг цуглуулахаар шийдсэн. Дараа нь эдгээр цаасан маягтуудыг PDF болгон хөрвүүлж, онлайнаар байршуулсан. Ингэснээр, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээлэлд хязгаарлагдмал дүн шинжилгээ хийх боломж олгосон хэдий ч,

ангилсан өгөгдлийн хомсдол нь түүний ашиг тусыг хязгаарлаж, ил болгосон мэдээллийг шалгахад илүү төвөгтэй болгосон.

2021 оны 9-р сард Армени улс анхны ангилсан өгөгдлөө нийтэлж, бүртгэлийн програмынхаа загварт стандартыг нэгтгэх замаар ЭӨӨС-ыг ашиглан өгөгдлийг нийтэлсэн анхны орнуудын нэг болсон.²⁶

Армени улсад зарим нэг саад бэрхшээл тулгарсан хэвээр байгаа хэдий ч, өгөгдлийн стандартыг баталснаар ЭӨ-ийн өгөгдлийг ашиглах шинэ боломж бий болгож, тус улсыг ЭӨӨС-д зориулан боловсруулсан төрөл бүрийн хэрэгслийг бүртгэлдээ шууд нэгтгэх боломжтой болгоно. Жишээ нь, ЭӨӨС-ын өгөгдлийн дүрсжүүлэлтийн сан нь хэрэглэгчдэд өгөгдөлд суурилсан өмчлөгчийн схемийг хялбар үүсгэх боломж олгох бөгөөд компанийн бүтцийг ойлгох, дүн шинжилгээ хийхэд хялбар болгоно.²⁷ Армени улс 2023 оны сүүлээс эхлэн Улсын бүртгэлээс авсан ЭӨ-ийн ангилсан өгөгдлийг худалдан авах ажиллагааны системдээ авлига, хуйвалдаан, засгийн газрын тендерийн будлиантай тэмцэх хэрэгсэл болгон ашиглахаар төлөвлөж байна.

Зураг 2. Армени улсын 2018 оны ангилаагүй эцсийн өмчлөлийн мэдүүлэг (зүүн) болон 2022 оны эцсийн өмчлөгчийн өгөгдлийн портал дээрх Эцсийн өмчлөлийн өгөгдлийн стандарт дүрслэлийг ашиглан гаргасан ангилсан эцсийн өмчлөлийн мэдүүлгийг (баруун) харьцуулж харуулав

Քաթին ԼՍԻ Կազմակերպություն

1. Կազմակերպության հվալմեր

Սազամար ՑԲԸ	SAGAMAR CJSC
(անվանումը)	(անվանումը լատինական (անկաղություն րեկտում))
278, 120, 03167	14.02.2002թ
(գրանցման համարը)	(գրանցման օղը, ամիսը, արին)

2. Գեմվելու վաղը

(վերոդի անվանումը, համարը, հունը)	(վերոի վերը, բաղը)	(վերոլությունը)
-----------------------------------	--------------------	-----------------

3. Հառուկ մասնակցություն

☐ 3.1. Կազմակերպությունը պեսական (վերական մասնակցությունը) իրավաբանական անն է

(վերոյան անվանումը)	Հսկողության մակարդակ՝
	☐ Միաննա
	☐ Վլլ աննի (աննանը) հես համաեսել
(մասնակցության շաղը (%))	


☐ 3.2. Կազմակերպությունը համալրալին (համալրալին մասնակցությունը) իրավաբանական անն է

(համալրի անվանումը)	Հսկողության մակարդակ՝
	☐ Միաննա
	☐ Վլլ աննի (աննանը) հես համաեսել
(մասնակցության շաղը (%))	

☐ 3.3. Կազմակերպությունը միջազալին կազմակերպություն (միջազալին կազմակերպության մասնակցությամբ) իրավաբանական անն է

(միջի կազմակերպության անվանումը)	Հսկողության մակարդակ՝
	☐ Միաննա
	☐ Վլլ աննի (աննանը) հես համաեսել
(մասնակցության շաղը (%))	

4. Իրական սեփականաեր չունենալու մասին հայաարություն



Зураг 3. Bluetail: Эцсийн өмчлөлийн ангилсан өгөгдөл болон гэрээний ангилсан өгөгдлийг нэгтгэх нь

 Ministry of Efficiency

Tenders ▾ Spending analysis

Tenders in progress » Tachograph Forensic Services » Mitchell Systems Ltd.

Mitchell Systems Ltd.

Tender application

PROC-20-0001/c

Applicant

Mitchell Systems Ltd.

Company name

Mitchell Systems Ltd.

Company ID

[GB-LAC] 5315469852

Country of registration

United Kingdom

3 warnings

Ашиг сонирхлын зөрчил, тендерийн луйврын улмаас нягтлах шаардлагатай мэдээллийг анхааруулсан.

Beneficial owners

Antony Wade

2

Full name

Antony Wade

This person has control over multiple applicants to this tender.

Name and ID match a currently serving cabinet minister.

Parent companies

Sunrise Taylor Hunt Ltd.

1

Company name

Sunrise Taylor Hunt Ltd.

Company ID

This company appears in multiple applications to this tender.

Country of registration

GB

Mitchell Wade LLC.

Company name

Mitchell Wade LLC.

Company ID

Country of registration

US

ABG Group Ltd.

Company name

ABG Group Ltd.

Company ID

Country of registration

GB

ОО нь mySociety болон Spend Network-ийн хөгжүүлсэн Bluetail нэртэй загвар дээр бүтээгдсэн бөгөөд энэ нь ЭӨӨС-д нийтлэгдсэн ангилсан өгөгдөл болон Нээлттэй гэрээний өгөгдлийн стандартад нийтлэгдсэн өгөгдлийг хэрхэн харилцан ажиллах боломжтойг харуулдаг. Худалдан авах ажиллагааны ажилтнууд тендер шалгаруулах явцдаа авлига, хуйвалдааны нягтлах шаардлагатай мэдээллийг автоматаар тодорхойлохын тулд эдгээр багц өгөгдлийг нэгтгэж болно.²⁹ Эх сурвалж: bluetail.herokuapp.com.



Ангилсан өгөгдөл нь нөхцөл байдлаас хамаарсан харилцан ажиллах боломжийг сайжруулдаг. Жишээ нь, хуулийн этгээдэд зориулсан нэг онцгой таних тэмдэг нь харилцан ажиллах боломжийг сайжруулж болох хэдий ч, org-id.guide³⁰-ийн боловсруулсан арга гэх мэт компанийн таних тэмдгийг оноох, хоёрдмол утгыг арилгах нийтлэг аргыг хэрэглэх нь илүү бодитой бөгөөд харилцан ажиллах илүү боломжтой багц өгөгдлийг бий болгож болно. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын өгөгдлийн нийтлэг тайлангийн стандарт нь нөхцөл байдлаас хамаарсан харилцан ажиллах боломжтой байдлын өөр нэг жишээ юм.³¹ Нөхцөл байдлаас хамаарсан харилцан ажиллах өндөр түвшний боломжтой байх нь өгөгдлийг цэвэрлэхэд зарцуулагдах нөөцийг өгөгдлийн дүн шинжилгээнд зарцуулах боломж олгоно. Байгууллагын өгөгдөл дэх хиймэл оюун ухааны хүчин чармайлтын дийлэнх хэсгийг одоогоор өгөгдлийг хоёрдмол утгагүй болгоход зарцуулж байна. Бодлого боловсруулагчид зохицуулалтын асуудал дээр ажиллах байр суурьтай байгаа нь ингэх шаардлагыг бууруулна. Илүү хөгжсөн, тогтсон хэдий ч, нягт холбоотой талбарууд нь харилцан ажиллах боломжтой, ангилсан өгөгдлийг суурь болгох замаар дундын дэд бүтцийг бий болгоход хэрэгцээтэй загвараар хангана.

Ил тод зарлах шаардлагад нийцүүлэх

Мэдүүлэгч компаниудын эцсийн өмчлөгчийг зарлах, төвлөрсөн бүртгэлд зориулж ангилсан өгөгдлийг гаргахад илүү хямд тусдаг. Төвлөрсөн бүртгэл нь компаниудыг дотоод үйл ажиллагаа, журмаа стандартчилах боломжтой өгөгдлийг онлайн хэлбэрээр мэдүүлэх стандарт арга замаар хангаж чадна. Мэдээлэл ирүүлэх ажлыг хялбаршуулах, алдааг багасгахын тулд, Армени улс мөн мэдүүлгийн үйл ажиллагаанд ЭӨӨС-ын дүрсжүүлэлтийн санг мөн ашигладаг (Нүд 5 харна уу). Харин ангилаагүй өгөгдлийг мэргэжилтний мэдлэгийг шаардаж болох төрөл бүрийн тусгай процессуудыг ашиглан янз бүрийн хэлбэрээр цуглуулж болно. Ангилаагүй мэдээлэлтэй адилаар дан ганц гар аргаар хийх үнэтэй шалгах ажиллагаанд найдахаас илүүтэйгээр, ирж буй мэдээллийг баталгаажуулдаг бүртгэлүүд нь бусад багц өгөгдөлтэй харьцуулан шалгахын тулд ангилсан өгөгдлийг ашиглаж болно.³²

Бодлогын нөлөөг ихэсгэх

Дээр дурдсан давуу талууд нь бодлогын үр дүнд хүрэхэд илүү сайн сонголт болдог тул, ангилсан ЭӨ-ийн өгөгдлийн ЭӨИТБ-ын бодлогын зорилгод хүрэх магадлал нь ангилаагүй өгөгдлөөс илүү өндөр байдаг. ЭӨ-ийн мэдээллийг бодлогын тодорхой зорилгод хүрэхийн тулд дангаар нь ашиглах нь ховор байдаг тул, бусад багц өгөгдөлтэй хослуулан хэрэглэхэд хамгийн их үнэцэнэтэй байдаг. Хэрэгцээтэй байлгахын тулд, эцсийн өмчлөлийн өгөгдөл нь компани эсвэл хувь хүмүүсийн хувийн мэдээлэл, үйл ажиллагааны талаарх өгөгдөлтэй уялдаатай байх ёстой. Ангилсан өгөгдөл нь нийтлэг талбаруудыг нэгтгэх замаар ЭӨ-ийн мэдээллийг бусад багц өгөгдөлтэй холбох боломжтой болгодог.

Үндэстэн дамнасан өмчлөлийн бүтцийн талаарх бүрэн дүр зургийг гаргахын тулд, ЭӨ-ийн өгөгдлийг өөр улс орнуудын бусад ЭӨ-ийн багц өгөгдөлтэй холбож болно. Ялангуяа авлига, мөнгө угаах тохиолдлуудын үед хэд хэдэн улс орныг хамарсан нарийн төвөгтэй бүтцээр дамжуулан эцсийн өмчлөлийг тодорхойлох ажлыг хэрэгжүүлж болно. Дэлхийн банкнаас гаргасан 150 орчим томоохон авлигын хэргийг судлахад, бараг бүх хэрэгт өмчлөгчийг нуун дарагдуулахын тулд халхавчилсан компани ашигласан бөгөөд ихэнх тохиолдолд үндэстэн дамнасан зохион байгуулалтаар хийсэн байна.³³ Ийм бүтэц зохион байгуулалтын талаарх нарийвчилсан мэдээлэл нь нэг улс орны нээлттэй мэдээллээс бүрэн харах боломж ховор бөгөөд компанийн өмчлөлийн үндэстэн дамнасан шинж чанарыг ойлгохын тулд өөр өөр улс орнуудаас авсан олон тооны ЭӨ-ийн багц өгөгдлийг нэгтгэх эсвэл хууль ёсны өмчлөгчийн өгөгдлийг ЭӨ-ийн өгөгдөлтэй нэгтгэх шаардлагатай болдог. Харилцан ажиллах боломжтой өгөгдөл нь хэд хэдэн бүртгэлийн мэдээллийг нэгтгэх ажлыг хялбаршуулдаг. Халхавчилсан компанийг зүй бусаар ашиглахтай тэмцэхэд үндэстэн дамнасан шалгалт, үндэстэн дамнасан шалгалтын ажиллагааг бий болгох нь хоёр тэргүүлэх чиглэл хэмээн Дэлхийн банкны судалгаанд тодорхойлсон байдаг. “Үндэстэн дамнасан халхавчилсан компанийг буруугаар ашиглах схемийг илрүүлэх нь дутуу хэсгүүдийг нь тус тусдаа барьсан өөр өөр улсын мөрдөн байцаагч нарын хувьд, зарим хэсэг нь байхгүй эвлүүлдэг тоглоомыг эвлүүлэх гэж оролдохтой адил зүйл юм. Эвлүүлдэг тоглоомыг эвлүүлж дуусгахын тулд мөрдөн байцаагч бүх хэсгүүдийг үзэх боломжтой байх шаардлагатай.”³⁴ Үндэстэн дамнасан өмчлөлийн бүтэц зохион байгуулалтын талаарх мэдээллийг олж харах нь шалгалтын өөр шинэ талбар руу чиглүүлэх нөөцийг хэмнэнэ (жишээ нь, Нүд 6 харна уу).

ЭӨ-ийн өгөгдлийг өөр зорилгоор хувь хүн эсвэл хуулийн этгээдийн бусад багц өгөгдөлтэй мөн нэгтгэж болно. Жишээ нь, худалдан авах ажиллагаа болон



эцсийн өмчлөлтэй холбоотой багц өгөгдлийг хуулийн этгээдийн нийтлэг таних тэмдгийг ашиглах замаар холбож болно.³⁵ Түүнчлэн, сонгуулийн үйл явцыг хамгаалахын тулд, ЭӨ-ийн өгөгдлийг улс төрийн кампанит ажлын санхүүжилтийн өгөгдөлтэй нэгтгэж болно.³⁶ Багц өгөгдлийг дундын таних тэмдэггүйгээр холбох боломжтой хэвээр байгаа хэдий ч, аль бүртгэл

нь нэг хуулийн этгээд эсвэл хүнтэй холбоотой болохыг тодорхойлохын тулд өгөгдлийг нэгтгэх шаардлагатай ба энэ нь цаг хугацаа их шаарддаг, тодорхой бус үйл ажиллагаа юм.³⁷ Тиймээс жинхэнэ байгууллагын таних тэмдэг нь ангилсан өгөгдлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал шаардлага юм (жишээ нь, Нүд 6 харна уу).

Нүд 6: OpenSanctions ба OpenScreening: Жинхэнэ байгууллагын таних тэмдэг ашиглан эцсийн өмчлөл болон хориг арга хэмжээний өгөгдлийг нэгтгэх

АНУ-ын Гадаад хөрөнгийн хяналтын албанд бүртгэлтэй хувь хүн эсвэл компаниудын эсрэг хориг арга хэмжээ нь зөвхөн тухайн хуулийн этгээдэд хамаарахаас гадна, тухайн хуулийн этгээд ихэнх хувийг нь эзэмшдэг эсвэл тухайн хуулийн этгээдийн удирддаг бүх компанид хамаарна.³⁸ Бусад зарим байгууллагуудын хэрэгжүүлдэг уг зохицуулалт нь компанийн бүтцийн бүрэн мэдээлэл, эцсийн өмчлөлийн ил тод байдлыг хориг арга хэмжээг дагаж мөрдөх зайлшгүй чухал хэсэг болгож байна.


OpenSanctions нь олон улсын өгөгдлийн сан бөгөөд хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг үндэсний ЭӨ-ийн бүртгэл зэрэг хэд хэдэн эх сурвалжаас цуглуулж, хориг арга хэмжээ болон улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалттай холбодог. Уг төсөл нь ийм мэдээллийг нэг өгөгдлийн санд нэгтгэх замаар өгөгдлийн сангуудыг харилцан шалгах, ашиг сонирхлын зөрчил, хууль бус үйл ажиллагааны шинж тэмдгийг илрүүлэх, мөн олон улсын наймаанд оролцож буй үйлчлүүлэгчдийг шалгах, дэлхий даяарх улс төрийн зөрчил, хориг арга хэмжээний бодлогыг хянах зорилготой юм.³⁹ Үүнийг хийхийн тулд давхардлыг арилгаж, олгосон таних тэмдэг болон тодорхойлох өгөгдлийн талбаруудад тулгуурлан хуулийн этгээд, хувь хүнд ногдох зөвхөн нэг нэгдсэн

бичилттэй байх шаардлагатай.⁴⁰ Ашиглах боломжтой мэдээллээс шалтгаалж, үүнийг гар ажиллагаагаар хийх шаардлагатай болж болно.⁴¹

OpenSanctions нь багц өгөгдлөө Хуулийн этгээдийн онцгой таних тэмдгийн сангаас (GLEIF) гаргасан Хуулийн этгээдийн таних тэмдгийн (LEI) лавлах өгөгдөлтэй тааруулна. GLEIF нь LEI олгосон компаниудын олон улсын өгөгдлийн санг⁴² үүсгэсэн бөгөөд компаниудын хоорондын өмчлөлийн харилцааны өгөгдлийг мөн нийтэлдэг.⁴³ Ингэснээр, OpenSanctions-д өгөгдлөө баяжуулж, нэмэлт харилцааг илрүүлэх боломж олгодог.⁴⁴

OpenScreening төслийн хувьд, OpenSanctions нь Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн консорциумаас (ICIJ) нийтэлсэн Offshore Leaks өгөгдлийн сангаас авсан ЭӨ-ийн өгөгдлийг OpenSanctions болон Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигыг мэдээлэх төслийн ашигладаг FollowTheMoney өгөгдлийн загвар руу нарийвчлан бүртгэсэн.⁴⁵ Дараа нь уг өгөгдлийг өөрийн OpenSanctions өгөгдлийн сантай нэгтгэж, Neo4J график өгөгдлийн санд байршуулж, Linkurious-аас өгсөн өгөгдлийн дүрсжүүлэлтийн платформд байршуулснаар хүмүүс хориг арга хэмжээ авсан эсвэл улс төрийн нөлөө нь ил болсон хүмүүс болон ЭӨ-ийн илчлэгдсэн өгөгдлийн хоорондын холбоог судалж, дүрслэн харуулах боломжтой болно.⁴⁶

Зураг 4. OpenScreening



OpenSanctions график өгөгдлийн жишээг Linkurious эрэн сурвалжлах програмтай нэгтгэсэн бөгөөд ОО-ын бүртгэлээс өгөгдөл авахаар төлөвлөж байна.⁴⁷ Эх сурвалж: resources.linkurious.com/openscreening.

ЭӨИТБ-ын бодлогын хүрээний тодорхой хэрэгцээнээс харвал, ангилсан өгөгдөл нь ангилаагүй өгөгдлөөс мөн ихээхэн давуу талтай гэсэн үг юм. Ангилаагүй ЭӨ-ийн мэдээлэл нь үйл ажиллагаа, зорилгод саад болох нөөцийн хязгаарлалтыг нэн даруй бий болгодог бол, ангилсан ЭӨ-ийн өгөгдөл нь шинэ төрлийн шинжилгээ, боломжийг нээж өгдөг (Зураг 4 харна уу). Ангилаагүй мэдээлэл нь их хэмжээний авлигын хэргүүдтэй холбоотой шалгалтын ажиллагаа гэх мэт цөөн хэдэн нөхцөлд л хэрэгжих боломжтой, нөөц их шаардах, хамрах хүрээ багатай дүн шинжилгээ хийхэд хүргэдэг. Ангилсан өгөгдөл нь бага зардлаар ЭӨ-ийн багц өгөгдлийг бүхэлд нь макро түвшинд болон туршилтаар шинжлэх боломж олгодог. Энэ нь ангилсан өгөгдөлгүйгээр хийх боломжгүй бодлогын янз бүрийн төрлийн нөлөөллийг нээж өгдөг. Жишээ нь: эдийн засгийн тодорхой салбарууд дахь ЭӨИТБ-тай холбоотой үндэсний аюулгүй байдлын эрсдлийг судлах; бодлогын зохицуулалтын үр дүнгийн статистик дүн шинжилгээ; эсвэл гар аргаар хийх шалгалтыг илүү нарийвчлалтай явуулахын тулд нягтлах шаардлагатай мэдээллийн журмыг боловсруулах. Их Британид Өрсөлдөөн, зах зээлийн алба нь нийтлэг өмчлөл, хяналтыг харгалзан үзсэний дараа тодорхой салбарууд дахь өмчлөлийн төвлөрөлд дүн шинжилгээ хийхдээ

ЭӨ-ийн өгөгдлийг ашиглаж эхэлсэн.⁴⁸ Өөр нэг жишээн дээр, судлаачид эрчим хүчний шилжилтэд зах зээлийн эрсдэлийг ойлгохын тулд, орхигдсон чулуужсан түлшний хөрөнгийн зураглалыг гаргахын тулд арилжааны компанийн өмчлөлийн багц өгөгдлийг (үүнд эцсийн өмчлөлийг багтаасан) ашигласан.⁴⁹

Мөн ангилсан өгөгдөл нь шалгах боломжтой мэдээлэлд цаг тухайд нь нэвтрэх боломж олгодог. Энэ нь ялангуяа хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлын зорилгод хамаатай бөгөөд сэжигтнийг анхааруулах эсвэл шалгалтын ажиллагааг хойшлуулах эрсдэл бүхий гар аргаар хайх, лавлагаа хийх шаардлагагүй болгоно. Автоматжуулсан хяналт болон нэвтрэлтийн бүртгэлүүд нь нууц эсвэл хязгаарласан мэдээллийг зохих ёсоор ашиглах баталгаа болно.

Эцэст нь, ангилсан өгөгдөл нь баталгаажуулалт, нийт бүртгэлийн хэмжээний дүн шинжилгээ хийх замаар илүү найдвартай өгөгдөл, уян хатан системийг бий болгох боломжтой болгодог. Үүнд бүртгэлд ирүүлсэн өгөгдлийг автоматаар шалгах; босго туршилтад тулгуурласан шалгалт, сорилт; мөн ирүүлсэн өгөгдлийн мета өгөгдлийг цуглуулах, дүн шинжилгээ хийх (компани үүсгэн байгуулах тодорхой төлөөлөгчдийг



ашиглах гэх мэт) зэрэг ажиллагаа орох ба системийн тодорхой хэсэгт эмзэг байдлыг илрүүлж болно. Энэ нь мөн хувийн мэдээллийг нууцлал, мэдээлэл хамгаалах хууль журмын дагуу тодорхой өгөгдөл хэрэглэгчдэд өөр өөр өгөгдлийн талбарт харилцан адилгүй зөвшөөрөл үүсгэн харилцан ажиллаж болно гэсэн үг юм. Жишээ нь, иргэний үнэмлэхийг баталгаажуулахын тулд өөр төрийн байгууллагад паспортын дугаарыг шалгаж байгаа бүртгэгч нэмэлт хувийн мэдээлэл өгөхгүйгээр утгууд нь одоо байгаа бүртгэлтэй тохирч байгаа эсэх талаар мэдээлэл авах боломжтой болно.⁵⁰



Эцсийн өмчлөлийн ангилсан өгөгдлийг хэрэглэх нь

ЭӨ-ийн ангилсан өгөгдлийг ашиглахын тулд хэрэгжүүлэгчид дараахыг анхаарна. Үүнд:

- таатай орчин бүрдүүлэх;
- ЭӨ-ийн мэдээллийг цуглуулах, хадгалах зарчмыг тодорхойлох;
- боломж бололцоогоо ухамсарлаж, хэвлэн нийтлэх үе шатанд тодорхойгүй байдлыг арилгах.

Таатай орчин бүрдүүлэх

Ангилсан өгөгдлийн боломж бололцоо нь эцсийн дүндээ хууль эрх зүй, зохицуулалт, улс төрийн орчноор хязгаарлагддаг. Эдгээр талбаруудад тогтоосон хязгаарлалтыг ямар ч техникийн ажиллагаа даван туулж чадахгүй. Иймд, бодлого боловсруулагчдын хамгийн чухал ажил нь ЭӨИТБ-тай холбоотой техникийн зорилтуудад хүрэхийн тулд, хууль эрх зүй, зохицуулалт, бодлогын тогтолцоог бий болгож, үе шаттайгаар сайжруулах явдал юм.

Хэрэглэгч төвтэй, давтагдах арга

Хэрэгжүүлэгчид технологид хэрэглэгч төвтэй аргыг баримтлах ёстой. Энэ нь оролцогч талуудын сонирхол, оролцоог хангаж, зорилгод нийцсэн системийг бий болгоно.⁵¹ Хэрэгжилтийг нэг удаагийн төсөл биш, давтагдах үйл явц гэж үзвэл зохино. Зарим эхэн үеийн бүртгэлүүдийн амжилт нь тэдний давтагдах аргаас хамаарч байсан (жишээ нь, [Нүд.3](#) харна уу). Хэрэгжилтийн хүрээнд болон хэрэгжүүлсний дараа өгөгдөл хэрэглэгчдийг татан оролцуулж, системээ үе үе сайжруулснаар анхан шатны хэрэгжүүлэгчид нь одоо ЭӨИТБ-ын үр дүнтэй шинэчлэлийн тулгын чулуу гэж тооцогдож буй элементүүд дээр санал нэгдсэн.

Хууль тогтоомж нь давтагдах аргыг дэмжих ёстой. Хэрэв хууль тогтоомж нь хэтэрхий хатуу заалттай байвал, бүртгэлийн удирдлагын аливаа жижиг өөрчлөлтөд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

болно. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах нь цаг хугацаа, хүчин чармайлт их шаарддаг бөгөөд хууль тогтоох байгууллагаар хэлэлцэх бүрд улс төрийн сөрөг нөлөөнд нээлттэй байдаг тул, энэ нь дахин давтагдах магадлалыг бууруулж болно. Харин, хэрэв бүртгэгчид илүү уян хатан байх боломж олговол, эдгээр давталтуудыг хийхэд хялбар байх болно. Үүний нэг жишээ нь улс орнуудад хоёрдогч хууль тогтоомж эсвэл журмын хүрээнд ЭӨ-ийн мэдүүлгийн маягтыг багтаах явдал юм. Энэ нь үүссэн аливаа саад бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд, бүртгэгчийг мэдээлэл цуглуулах маягтыг давтан сайжруулах боломжгүй болгодог (жишээ нь, [Нүд.3](#) харна уу).

Хууль эрх зүй, бодлогын орчин

Давтагдах аргыг хялбаршуулахаас гадна, ЭӨИТБ-ын бодлогын зорилтуудад хүрэхийн тулд хангалттай өгөгдөл цуглуулах эрх зүйн орчин бий болгох нь чухал юм. Ангилсан өгөгдлийн хэрэгцээтэй байдал нь ЭӨ-ийн суурь мэдээлэл хэр үнэн зөв, найдвартай, нарийвчилсан, шинэчлэгдсэн, иж бүрэн, аудит хийх боломжоор хязгаарлагддаг. ОО-ын зарчим нь хэрэгжүүлэх үйл явцын эдгээр чухал үе шатуудын үед мэдээллийн чанарыг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлдэг.⁵² Өгөгдөл цуглуулах, баталгаажуулах, хуваалцахын тулд баримт бичгийг таних тэмдгийн бүртгэлтэй эсвэл санхүүгийн байгууллагуудын эзэмшиж буй мэдэгдэлтэй тулгаж баталгаажуулах гэх мэт олон байгууллагуудын хооронд гэрээ байгуулах шаардлагатай болж болно. Ийм төрлийн гэрээ хэлэлцээрийг тохиролцож, ажиллагааг эхлүүлэхэд цаг хугацаа их шаардагддаг тул, аль болох эрт эхлүүлэх хэрэгтэй. Хууль тогтоомжид ЭӨ-ийн өгөгдлийг ангилах талаар нарийвчилж оруулах нь ховор байдаг хэдий ч, дараах бүх шинж чанарууд нь хатуу хууль эрх зүйн тогтолцооны нэг хэсэг юм.

- эцсийн өмчлөлийн найдвартай тодорхойлолт;
- иж бүрэн цар хүрээг хамруулах, хангалттай мэдээлэл цуглуулах;



- ЭӨ-ийн мэдүүлэг гаргахад шаардлагатай мэдээлэл, холбогдох хүчин зүйлсийг ил тод болгох хууль ёсны үүргийг бий болгох;
- хувийн нууц, мэдээлэл хамгаалах хууль тогтоомжид нийцүүлэн мэдээлэл боловсруулах, нийтлэх эрх зүйн зөв үндэслэлийг бий болгох;
- баталгаажуулахын тулд өгөгдлийн зөв гэрээ хэлэлцээрийг бэлэн байлгах;
- дүрэм журмыг дагаж мөрдөх, өгөгдлийн чанарыг сайжруулах хориг арга хэмжээ, хэрэгжүүлэх дүрмийг боловсруулах.⁵³

Технологийг хувийн нууцлал, аюулгүй байдлыг хэрэгжүүлэх тулгын чулуу болгон ашиглаж болно. ЭӨ-ийн талаарх бүх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах шаардлагагүй бөгөөд ангилсан өгөгдөл нь бүрэн эсвэл хэсэгчилсэн багц өгөгдөлд зохих нэвтрэх эрхтэй хүмүүст хянах, аудит хийх хамгийн хялбар, найдвартай арга замыг бий болгоно. Жишээ нь, дотоодын байгууллагуудыг бодвол бага хэмжээний өгөгдлийн хэсгийг олон нийтэд нээлттэй болгож, шаталсан нэвтрэх эрх гэж нэрлэгддэг онцгой эмзэг өгөгдлийн талбаруудыг орхигдуулах замаар үүнийг хэрэгжүүлнэ. Мэдээллийг ил тод болгох ердийн журмаас үл хамаарах зүйл, аль хэдийн нийтэлсэн өгөгдлийг буцаах, хасах боломж олгодог хамгаалалтын дүрмийг бий болгох нь бас чухал юм.⁵⁴ Ангилсан өгөгдөл нь дараа нь засварлаж болзошгүй өгөгдлийг ашиглах, дахин нийтлэхтэй холбоотой зардал, эрсдлийг бууруулдаг. Ангилсан өгөгдөл нь нууцлал, аюулгүй байдлын арга хэмжээг улс орнуудын хооронд зохицуулах боломж олгож, бодитоор хасагдсан тохиолдолд санамсаргүйгээр ил тод болгох эрсдлийг бууруулдаг.

Нөөц

Бодлого боловсруулагчид ЭӨИТБ-ын бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд техникийн нөөцийн асуудлаар саад учруулахгүй байх ёстой. ЭӨИТБ нь өргөн цар хүрээтэй, урт хугацааны шинж чанартай хүлээгдэж буй үр ашиг бүхий цогц бодлогын оролцоо бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд засгийн газар хоорондын зохицуулалт, тогтолцоо, үйл явц дахь томоохон өөрчлөлтүүдийг хамардаг. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэх чадвартай техникийн системийг санхүүжүүлэх нь хэцүү ажил байж болно. Аливаа техникийн үйл ажиллагаа нь нэг төрийн байгууллагад хэрэгжүүлэх зардлыг багасгах биш, харин хүлээгдэж буй бодлогын үр ашгийг бүрэн тодорхойлох зориулалттай байвал зохино. Эдгээр үр өгөөж нь ихэвчлэн хэрэгжүүлэгч агентлагаас гаднаас цуглардаг тул төсөв бүрдүүлэхэд цогц арга барил шаардлагатай.⁵⁵ Техникийн нөөцөөс гадна ЭӨ-ийн мэдээллийг ил тод болгох дүрэм нь мэдээллийн бүрэн бүтэн байдлыг

хангахад дагаж мөрдөх, хориг арга хэмжээ хэрэгжүүлэх, өгөгдлийн лавлагаа, баталгаажуулалтад хангалттай нөөцтэй байхыг мөн шаарддаг.

Эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулах, хадгалах зарчмыг тодорхойлох

ЭӨ-ийн мэдээллийг цуглуулах, хадгалах зарчмуудыг бий болгохдоо хэрэгжүүлэгчид ЭӨ-ийн ангилсан өгөгдлийн хамгийн наад захын гол элементүүдийг анхаарч үзэх ёстой бөгөөд эдгээр болон бусад элементүүдийг системийн загварт оруулах хэрэгтэй.

Эцсийн өмчлөлийн ангилсан өгөгдлийн үндсэн элементүүд

ЭӨ-ийн өгөгдөл нь хувь хүн, хуулийн этгээдийн хоорондын өмчлөл, хяналтын харилцааг тайлбарладаг. Мэдээлэл ил болгох дүрмээс хамаарч эдгээр харилцааг өгөгдөл гэж тайлбарлавал энгийн эсвэл илүү төвөгтэй байж болох хэдий ч, ЭӨ-ийн өгөгдлийн гүйцэтгэх ёстой гурван үндсэн функц өөрчлөгдөөгүй хэвээр байна. Ангилсан өгөгдлийн хувьд эцсийн өмчлөл нь:

1. ЭӨ-ийн мэдэгдэлд ил болгосон хүмүүс, компани болон бусад холбогдох этгээдүүдийг тодорхойлох;
2. ЭӨ-ийн мэдэгдэлд ил болгосон этгээдүүдийн (нэр бүхий этгээдүүд гэх мэт) ашиг сонирхол, харилцааны мөн чанарыг тайлбарлах;
3. ЭӨИТБ-ын ил болгосон мэдээлэлд аудит хийх боломжтой, харилцан ажиллах боломжтой байлгах.

Хүмүүс, компани болон бусад холбогдох этгээдүүдийг тодорхойлох

ЭӨ-ийн өгөгдөл нь энэхүү ЭӨИТБ-ын дүрмийн дагуу мэдүүлэг гаргаж буй бүх хуулийн этгээдийг тайлбарлах чадвартай байх ёстой бөгөөд мэдүүлгийн хүрээнд ил тод болгож болох бүх хуулийн этгээд, эзэмшлийн зохион байгуулалтыг нэгтгэхэд хангалттай уян хатан байх ёстой. ЭӨ-ийн өгөгдөл нь ЭӨИТБ-ын мэдүүлэгт хамаарах хувь хүн, хуулийн этгээд, эзэмшлийн зохион байгуулалтыг тайлбарлах, олж тогтооход шаардлагатай талбаруудыг тодорхойлж, ангилах ёстой. Үүнд нэмэлт хоёр арга бий. Эдгээр нь:

1. ЭӨИТБ-ын үйл явцад оролцож буй хүн ба хүн бус хуулийн этгээдүүдийг давхардалгүй байдлаар тодорхойлохын тулд **онцгой, байнгын, шийдвэрлэх боломжтой таних тэмдгийг** ашиглахыг шаарддаг.⁵⁶ Таних тэмдэг нь бусад улс орнуудын эрх бүхий байгууллагууд гэх мэт өгөгдөл хэрэглэгчдийн хувьд утга учиртай байх ёстой.



Таних тэмдгүүдийн жишээнд олонд танигдсан компанийн бүртгэлээс олгосон компанийн дугаар, тодорхой нэг улсын иргэний бүртгэлийн дугаар эсвэл дотооддоо үүсгэсэн эцсийн өмчлөгчийн таних тэмдэг орно.⁵⁷ Таних тэмдэг нь багц өгөгдлийг үр ашигтай, найдвартай ашиглах боломжийг олгож, өгөгдлийг цэвэрлэх хэрэгцээг бууруулж, өндөр үр ашигтай дүн шинжилгээ хийх нөөцийг чөлөөлдөг. Гэлээ ч, зохих таних тэмдэг байх ёстой бөгөөд хэрэв байгаа бол цуглуулах, хадгалах, хэвлэн нийтлэхэд тохиромжтой байх ёстой. Иймд, дотоодын эцсийн өмчлөгчтэй холбоотой цуглуулсан таних тэмдгүүдийг эрэмбэлэх эсвэл давхардлыг нь арилгахыг дэмжих үүднээс зөвхөн дотооддоо үүсгэсэн таних тэмдгийг нийтлэхийг сонгох зэргээр таних тэмдгүүдийг цуглуулах ажлыг голчлон анхаарч, нөхцөл байдалтай нь уялдуулж авч үзэх хэрэгтэй.

Орон нутгийн бус хувь хүн эсвэл компаниудын онцгой таних тэмдгийг эрж олоход хэцүү байж болно. Жишээ нь, Канад улс Нийгмийн даатгалын дугаартай (SIN) хэдий ч, тус улсад ажилладаггүй гадаадын иргэдэд SIN байдаггүй. Тиймээс Британийн Колумби Мужийн эцсийн өмчлөлийн бүртгэлийн газар өөрийн улсын иргэний үнэмлэхээс өөр иргэний үнэмлэхийг баталгаажуулах арга байхгүй тул гадаадын иргэдээс өөр таних тэмдэг шаарддаггүй.

Гадаадын иргэнд заавал бүртгүүлэх (жишээ нь, компани шинээр бүртгүүлэх эсвэл үл хөдлөх хөрөнгө худалдаж авах үед) шинэ таних тэмдэг олгох, эсвэл одоо байгаа таних тэмдгийг олж авах шаардлагатай зарим үйл явцыг оруулах арга байж болно. Канадын хувьд, татварын албанд бүртгүүлснээр Нийгмийн даатгалын дугаар авах гэх мэт. Өөр нэг арга нь, АНУ-д төлөвлөсний дагуу дотооддоо шинэ таних тэмдэг үүсгэх юм.⁵⁸ Дотооддоо үүсгэсэн таних тэмдэг нь олон улсын хэмжээнд хуваалцахад илүү тохиромжтой хэдий ч, дагалдах мэдээлэлгүйгээр үнэ цэнэ багатай байх болно.

Одоо байгаа онцгой таних тэмдэг нь хоёр компани нэгдэх үед хувь хүмүүс эсвэл компаниудын хувьд байнга тогтмол байдаггүй гэдгийг хэрэгжүүлэгчид мөн мэдэж байх ёстой.

2. ЭЭИТБ-ын үйл явцад оролцож буй хүн ба хүн бус хуулийн этгээдүүдийн танигдах магадлалыг тодорхойлох боломж олгодог **тодорхойлох өгөгдлийн талбаруудыг** ашиглахыг шаарддаг. Тодорхойлох өгөгдлийн талбаруудын жишээнд: нэрс, төрсөн огноо, иргэншил, хувь хүмүүсийн холбоо барих хаяг; мөн нэр, бүртгүүлсэн улс, хуулийн этгээдийн төрөл, бүртгэлтэй хуулийн этгээдийн хаяг, утасны дугаар орно. Тодорхойлох

өгөгдлийн талбарууд нь таних тэмдэг байхгүй болон дундын таних тэмдэггүй хоёр эх сурвалжаас багц өгөгдлийг холбох шаардлагатай үед хэрэгцээтэй.

Аль ч тохиолдолд, магадлалын аргыг ашиглан хуулийн этгээдүүдийг тааруулж болно.⁵⁹ Боломжтой бол тодорхойлох өгөгдлийн талбаруудыг өгөгдлийн онцгой таних тэмдгийг орлуулах бус, нэмэлт болгон авч үзэх хэрэгтэй бөгөөд стандартчилагдсан хэлбэрт нийцэж байх ёстой.

Эдгээр аргууд нь өгөгдөл цуглуулах, хадгалахтай холбоотой хэдий ч, мэдээлэл нийтлэхээс үүсэх эрсдлийг хязгаарлахын тулд хэвлэн нийтлэгчид нууц өгөгдөл болох хувь хүмүүсийн онцгой таних тэмдэг бүхий бичиг баримтыг (үнэмлэх) нийтлэх боломжгүй байдаг гэдгийг анхаарах нь зүйтэй. Жишээ нь, хувийн үнэмлэх, татварын дугаар, нийгмийн даатгалын дугаар зэрэг мэдээллийг нийтлэх үед хувийн мэдээллийг хулгайлах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймд, улс орнууд ихэвчлэн бага хэмжээний өгөгдлийн хэсгийг олон нийтэд нээлттэй болгох шаталсан нэвтрэх эрхийн системийг хэрэгжүүлдэг.⁶⁰ Нийтийн хэрэгцээнд зориулж хамгийн бага хэдий ч, хангалттай хэмжээний дэлгэрэнгүй өгөгдлийг нийтлэхийн тулд, тодорхойлох өгөгдлийн талбаруудыг ихэвчлэн ашиглах боломжтой болгодог бөгөөд энэ нь аль аль нэмэлт арга барил шаардлагатай гэсэн үг юм.

Тодорхой мэдүүлгийн дүрэмд тулгуурлан юуг ил тод зарлах шаардлагатайг тодорхойлох нь техникийн хувьд төвөгтэй байж болох бөгөөд нууцлал, мэдээлэл хамгаалах хуулиар мөн хязгаарлагдаж болно (жишээ нь, Нүд 7 харна уу).⁶¹



Нүд 7: Эцсийн өмчлөлийг ил тод болгох ажлын хүрээнд жендэр, хүйсийн өгөгдөл цуглуулах

Жендэр болон хүйсийн өгөгдөл нь мэдээлэл хамгаалах зарим дүрмийн дагуу хувийн нууц өгөгдөл болдог тул, энэ нь тэдгээрийг боловсруулах хуулийн эрхзүйн босго өндөр гэсэн үг юм. Мэдээлэл хамгаалах зарчимд нийцүүлж, засгийн газар тодорхой зорилгоор шаардлагатай хэмжээнээс илүү мэдээлэл цуглуулах ёсгүй. ЭӨ-ийн мэдээллийг ил тод болгох хүрээнд хувийн мэдээллийг цуглуулах зорилго нь хувь хүмүүсийг хоёрдмол утгагүйгээр тодорхойлоход оршино. Ихэнх тохиолдолд, үүнд жендэр болон хүйсийн өгөгдөл заавал шаардлагагүй.

Гэлээ ч, ОО-ын судалгаагаар ЭӨ-ийн мэдээллийг ил тод болгох хүрээнд ийм өгөгдлийг цуглуулах нь эмэгтэйчүүд албан ёсны үнэмлэх авах боломж хязгаарлагдмал үед, онцгой ач холбогдолтой болохыг тогтоосон.⁶² Хэрэв ЭӨ-ийн мэдээлэл ил болгох дүрэм нь иргэний үнэмлэхний хуулбарыг цуглуулахаас хамаарч байвал, жишээ нь, ялангуяа компани шинээр бүртгүүлэх үед ийм мэдээлэл ил болгох шаардлагатай тул, энэ нь эмэгтэйчүүдийг эцсийн өмчлөгч болоход саад болж болзошгүй.

Хэрэв тухайн хүн албан ёсны хувийн үнэмлэх авах эрхгүй бол, хүйсийн өгөгдөл цуглуулах нь компанийн жинхэнэ эзнийг тодорхойлоход тусална. Энэ нь хүйс хамаарахгүй хүмүүсийн нэрс түгээмэл байдаг нөхцөлд мөн хамаарч болно. Хэрэгжүүлэгчид хуулийн дагуу бүх хувийн мэдээллийг цуглуулах зорилгоо тодорхойлж, хууль эрх зүйн үндсийг бий болгох ёстой.

Талуудын хоорондын харилцааг тодорхойлох

ЭӨ-ийн өгөгдөл нь ЭӨИТБ-ын мэдүүлэгт хамаарах хувь хүн, хуулийн этгээдийн хоорондын хамаарал, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг тайлбарлахад шаардлагатай талбар, ангиллуудыг тодорхойлох ёстой. Өгөгдөл нь наанадаж тодорхой мэдүүлэгтэй холбоотой эцсийн өмчлөгч болон мэдүүлэг гаргагч хуулийн этгээдийн хоорондын холбоог тогтоох ёстой. Талуудын харилцааны талаарх өгөгдлийг ил болгох дэлгэрэнгүй мэдээлэл нь мэдүүлгийн дүрмээс хамаарна.

Өгөгдлийг тодорхойлох шаардлагатай хоёр үндсэн хэсэг байдаг. Эдгээр нь:

1. Мэдүүлэг гаргагч компани болон эцсийн өмчлөгчийн хоорондох өмчлөлийн үргэлжилсэн хэлхээнд шаардлагатай нарийвчлалын түвшин. Энэ нь зөвхөн эцсийн өмчлөгчийг ил болгохоос эхлээд өмчлөлийн сүлжээг бүхэлд нь ангилсан өгөгдөл болгон ил болгох хүртэл байж болно.^f
2. Өмчлөх буюу хяналтыг хэрэгжүүлэх ашиг сонирхлын шаардлагатай нарийвчлалын түвшин. Үүнд өмчлөлийн төрлүүдийн тайлбар (жишээ нь, хувьцаагаар дамжуулан санал өгөх эрх эсвэл нэр бүхий этгээдээр дамжуулах өмчлөл); ашиг сонирхлын түвшин (жишээ нь, хувьцаа эзэмшиж байгаа тохиолдолд); тодорхой төрлийн өмчлөлийн талаарх нарийвчилсан мэдээлэл, мөн хувь хүмүүсийн эдийн засгийн үр ашиг хүртэх арга замууд; ил тод болгох дэглэмд шаардлагатай хяналтууд (жишээ нь, төрийн өмчит хуулийн этгээдийн ашиг сонирхлын мэдээллийг ангилан ил тод болгох); өмчлөл, хяналтын харилцаа эхлэх болон дуусах үеийн мэдээлэл орно. Дэлгэрэнгүй мэдээллийг мөн хэрэгцээтэй, ашиглах боломжтой байхаар ангилах ёстой бөгөөд өмчлөл, хяналт нь эдгээр нарийвчилсан мэдээллийг будлиулсан хийсвэрлэлийн өндөр түвшинд ангилагдсан байх ёсгүй (Нүд 8 харна уу).

^f Өмчлөлийн бүхэл бүтэн үргэлжилсэн хэлхээг ойлгохын тулд, хангалттай мэдээлэл цуглуулсан байх ёстой гэж ОО-ын хангалттай нарийвчлалын зарчимд заасан байдаг. Бүрэн өмчлөлийн үргэлжилсэн хэлхээний харагдах байдал нь янз бүрийн холбогдох хуулийн этгээдүүдийн өгсөн хэсэгчилсэн өмчлөлийн үргэлжилсэн хэлхээний мэдүүлгийн мэдээллийн харьцуулалтад тулгуурласан байж болно. Ямар түвшний нарийвчилсан мэдээлэл шаардлагатайг ойлгож, тодорхойлохын тулд, ОО нь ЭӨ-ийн тодруулгын дасгал ажлын дэвтрийг хэвлүүлсэн: Kadie Armstrong, "Beneficial ownership disclosure workbook", Open Ownership, June 2021, <https://www.openownership.org/en/publications/beneficial-ownership-disclosure-workbook>.



Нүд 8: Өмчлөл, хяналтын харилцааны талаарх нарийвчилсан мэдээлэл хангалтгүй нийтлэгдсэн өгөгдлийн ангиллын жишээ

Дараах хийсвэр жишээнд, зохиомол улсаар эцсийн өмчлөлийг ангилалд хуваасан байна. Эцсийн өмчлөгчийн мэдүүлэг бүрийн хувьд, мэдээлж буй этгээд жагсаалтаас өмчийн нэг ангиллыг сонгох шаардлагатай.

Ангилал Тодорхойлолт	
A	Мэдүүлэг ирүүлсэн хуулийн этгээдийн саналын эрх, саналын эрхтэй хувьцаа, хөрөнгийн багадаа 25%-ийг шууд болон шууд бусаар эзэмшдэг.
B	Аливаа гэрээ, ойлголт, харилцаа, эзэмшлийн зохион байгуулалтаар дамжуулан мэдүүлэг ирүүлсэн хуулийн этгээдэд дангаараа эсвэл бусадтай хамтран хяналт тавьдаг.
C	Тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийг сонгох эрх мэдэлтэй.
D	Тухайн хуулийн этгээдийн удирдлага, бодлогод давамгайлах нөлөө үзүүлэх эрх мэдэлтэй.
E	Тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхид бодитоор, албан ёсоор нөлөөлөх эрх мэдэлтэй.
F	Тухайн хуулийн этгээдийн хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй.
G	Нэр бүхий хувьцаа эзэмшигчид эсвэл нэр бүхий захирлуудаар дамжуулан мэдүүлэг ирүүлсэн хуулийн этгээдийг эзэмшдэг буюу удирддаг.
H	Тухайн хуулийн этгээдийг өөр арга хэлбэрээр эзэмшдэг буюу удирддаг.

Жишээ нь, нэр бүхий хувьцаа эзэмшигчээр дамжуулан эцсийн өмчлөлийг хэрэгжүүлдэг Жон Смитийн талаарх ЭӨ-ийн өгөгдлийг системээс ангилсан өгөгдөл болгон экспортлох үед дараах байдлаар харагдана:

```
{
  [...]
  "beneficialOwnerFullName": "John Smith";
  "beneficialOwnerCategory": "G"
  [...]
}
```

Үүнийг анх харахад ангилсан өгөгдлийн нийтлэл мэт санагдаж болох хэдий ч, энэ нь хэт их хураангуйлсан жишээ юм. Ангилал тус бүрээр өмчлөл, хяналтыг ойлгоход хэд хэдэн чухал нарийвчилсан мэдээллийг тодорхойлдоггүй. Энэ мэдээллийг түр сануулж, ангилсан өгөгдөл болгон нийтлэх шаардлагатай. Жишээ нь, G ангиллын хувьд энэ маягт нь тухайн нэр бүхий этгээд хэн болох талаарх мэдээллийг агуулдаггүй. Нэр бүхий этгээдийн мэдээллийг эцсийн өмчлөгч хяналтаа хэрэгжүүлэх нэмэлт зангилаа хэлбэрээр цуглуулах ёстой. Эцсийн өмчлөгч, нэр бүхий этгээд, тэдгээрийн хоорондын өмчлөлийн хяналтын харилцааны талаар хангалттай мэдээлэл нийтлэгдсэн байх ёстой. Түүнчлэн, өмчлөл, хяналтын ангилал нь өөр хоорондоо таардаггүй. Хувь хүн нэгээс олон ангилалд багтах эсвэл хуулийн этгээдийн удирдлага, бодлогод (D ангилал) голлох нөлөө үзүүлэхийн тулд, нэр бүхий этгээдийн эзэмшлийн зохион байгуулалтыг (G ангилал) ашиглаж болно.



Эцсийн өмчлөлийн мэдүүлгийг аудит хийх боломжтой байлгах

ЭӨ-ийн өгөгдөл нь хэрэгцээтэй байхын тулд, функцийг хувьд аудит хийх боломжтой байх ёстой. Аудит хийх боломжийг гурван түвшинд авч үзэж болно. Үүнд:⁶³

1. Бүх өөрчлөлтийн бүртгэлийг оруулаад ЭӨ-ийн талаарх бүх мэдээллийн⁶⁴ бүрэн түүхэн бүртгэлийг хадгалснаар залилан хийх эрсдлийг бууруулж, системийн бүрэн бүтэн байдлыг сайжруулдаг. Энэ нь цаг хугацаатай холбоотой болон захиргааны мэдээллийг цуглуулж, хадгалж, нийтэлнэ гэсэн үг юм. Ийм өгөгдлийн жишээнд: мэдүүлэг ирүүлсэн огноо; харилцаа эхэлсэн ба дууссан огноо; одоо байгаа өгөгдлийг баталгаажуулсан жилийн тайланг нийтлэх зэрэг зүйлс орно. Хугацааны өгөгдлийг эртхэн авч үзэх нь чухал юм. Үүний хэрэгцээг хууль, дүрмээс гаргах хэрэгтэй байж болно.
2. Өгөгдөл хэзээ, яагаад алга болсон, үл мэдэгдэх болсон, засварласан талаарх ил тод байдлыг хангаснаар, ЭӨ-ийн өгөгдлийг хоёрдмол утгагүй ойлгох боломжтой болно. Үүнд, жишээ нь, хувийн мэдээллийг хамгаалах дүрмийн дагуу нийтэд мэдээллийг ил болгохоос хамгаалах хүсэлтийг хүлээн авсан эсэх;⁶⁵ солилцсон мэдээлэл нь ил тод байдал, ил тод зарлах тодорхой шаардлагыг хангаж байгаа тул хувьцаат компанийн мэдээлэл ил болгохоос чөлөөлөх эрхтэй эсэх;⁶⁶ эсвэл хувь хүн энэ тодорхойлолтыг хангаагүйгээс эсвэл эцсийн өмчлөлийг илрүүлж чадаагүйгээс болж эцсийн өмчлөлийн талаар мэдээлээгүй нөхцөл байдлууд орно.⁶⁷
3. Өгөгдлийг нийтлэх формат, нэвтрэх эрхийн дүрэм, стандартчиллын талаар шийдвэр гаргах замаар ЭӨ-ийн өгөгдөлд нэвтрэх, дүн шинжилгээ хийхэд тулгарч буй бодит саад бэрхшээлийг багасгана.

Эцсийн өмчлөлийн өгөгдлийг цуглуулах, хадгалах, хуваалцах системийг хөгжүүлэх

ЭӨ-ийн мэдээллийг цуглуулах, хадгалах, засварлах, солилцох, нийтлэх боломжтой байхын тулд, дижитал системүүд болон удирдлагын процессууд хоорондоо жигд нийцэж байх шаардлагатай. Хэрэгжүүлэгчид нь системүүд болон бизнесийн үйл явцыг загварчлахдаа техникийн түвшний шинэчлэлийн зорилтуудтай нийцүүлэх, дэмжих ёстой. Бодит байдал дээр, хэрэгжүүлэгчид дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- ЭӨИТБ-ын бодлогын хэрэгцээ нь системийн архитектур болон өгөгдлийн сангийн загварын шийдвэрт гол байр суурь эзэлж байх ёстой бөгөөд дээр дурдсан ЭӨ-ийн өгөгдлийн онцлог шинж чанаруудыг аль алиныг нь харгалзан үзсэн байх ёстой. Энэ шатанд хэрэгжүүлэгчид өгөгдлийн сангийн загварыг нийтлэх үе шатанд хүлээгдэж буй лавлагаа болон өгөгдлийн нэвтрэлттэй тааруулах нь чухал юм.⁶⁸ Жишээ нь, өгөгдлийн сангийн загвар нь хувь хүний өмчлөл, хяналтанд байдаг бүх компаниудын талаар мэдээлэл авах боломжийг хэрэглэгчдэд олгох уу? Энэ шатны хангалтгүй загвар нь цаашдын ашиглах боломжуудыг хязгаарлана.
- Системийн загварт эхлээд дижитал болгох аргыг хэрэглэж, дижитал технологийн давуу талыг ашиглана. Тухайлбал, мэдүүлгийн үед мэдээллийг баталгаажуулах замаар өгөгдлийн чанар, найдвартай байдлыг сайжруулах гэх мэт.
- Өгөгдөл цуглуулах, хадгалах, хуваалцах арга барицыг ЭӨИТБ-ын дүрмийн зорилтуудтай нийцүүлнэ. Ангилсан өгөгдлийг бий болгох нь шалгадаагүй дүрэм, удирдамжид байж болох хоёрдмол байдлыг арилгахыг шаарддаг. Үүнийг загварчлах (маягт гэх мэт) болон үзүүлэлтийн үе шатанд, холбогдох байгууллагуудтай хамтран хийсэн нь дээр.⁶⁹
- Бизнесийн үйл явцын талаарх шаардлагатай мэдээллийг үүсгэж, цуглуулж, хадгална. Ийм мэдээллийг цуглуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх нь ЭӨИТБ-ын мэдээллийг ил тод болгох системийн бүрэн бүтэн байдлын талаар үнэ цэнэтэй ойлголтыг өгч чадна. Хэрэгжүүлэгчдийн цуглуулахад үнэ цэнэтэй байж болох мэдээллийн жишээнд: компани үүсгэн байгуулах төлөөлөгч гэх мэт өгөгдөл ирүүлэхэд оролцсон эрх бүхий зуучлагчдын нарийвчилсан мэдээлэл; илгээх, хянах, нийтлэх үйл явцтай холбоотой гол огноонууд; үйл явц, хүмүүсийн дотоод таних тэмдгүүд; дотоод бодлогоор шаардаж болох дотоод нэвтрэх эрхийн бүртгэлүүд орно.⁹

⁹ Дотоод нэвтрэх эрхийн бүртгэлийн хэрэгцээний талаар иж бүрэн хяналт байхгүй хэдий ч, АНУ-ын дотоодын зарим хууль тогтоомжоор дараах зүйлсийг шаардаж болно. Эдгээр нь: Adam Smith, "William M. (Mac) Thornberry National Defense Authorization Act for Fiscal Year 2021", 116th United States Congress, 1 January 2021, 1241, <https://www.congress.gov/116/bills/hr/6395/BILLS-116hr6395enr.pdf>.



Боломж бололцоогоо ухамсарлаж, хэвлэн нийтлэх үе шатанд тодорхойгүй байдлыг арилгах

ЭӨ-ийн өгөгдлийг нээлттэй өгөгдлийн хэлбэрээр олон нийтэд нээлттэй болгосноор, тодорхой бус байдлыг арилгаж ашиглах, нэвтрэхэд учирч болзошгүй саад тотгорыг арилгах арга замаар өгөгдлийг ашиглахад бэлэн болгож, ЭӨИТБ-ын бодлогын янз бүрийн зорилтуудад хувь нэмрээ оруулах боломжтой өгөгдөл хэрэглэгчдийн бүлгийг өргөжүүлнэ.⁷⁰ Өгөгдлийг бусдад хүртээмжтэй, ойлгомжтой, ашиглах боломжтой болгохын тулд хэрэгжүүлэгчид дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Эдгээр нь:

- ЭӨ-ийн өгөгдлийг хэвлэн нийтлэх, ангилахдаа нээлттэй стандартыг ашиглах;
- Зохих лиценз, дагалдах баримт бичиг, хэвлэн нийтлэх бодлого бүхий түүхэн өгөгдөл зэрэг янз бүрийн хэлбэртэй өгөгдөлд нэвтрэх боломжийг олгох замаар нийтлэгдсэн өгөгдлийн аудит хийх боломжтой байлгана.

Нээлттэй стандарт

Нээлттэй стандарт нь гаргах, хэрэгжүүлэх, шинэчлэхэд чөлөөтэй байдаг стандартууд юм. Нээлттэй стандарт нь өгөгдлийг хэрхэн бий болгох, мөн өгөгдлийг нийтлэх форматад хамаарч болно. Төхөөрөмжөөр унших боломжтой, нээлттэй, салбарын стандарт форматыг ашиглахыг зөвлөж байна. CSV хэлбэр нь хүснэгтэн өгөгдөлд тохиромжтой сонголт хэдий ч, ихэнх ЭӨ-ийн өгөгдөл нь шаталсан бүтэцтэй байдаг. Хэрэв өгөгдлийн бүтцэд торлол байгаа бол, CSV нь хүмүүс мэдээллийг андуурч холбоход хүргэж болзошгүй, эсвэл давхардлаас болж шаардлагатай хэмжээнээс их хэмжээгээр мэдээллийг илэрхийлэхэд хүргэж болзошгүй. JavaScript Object Notation (JSON) нь шаталсан өгөгдөлд тохиромжтой сонголт болох нь батлагдсан нээлттэй стандарт файлын формат юм. Энэ нь онлайн харилцааны бодит стандарт болсон. Гэлээ ч, шинжээчид үүнтэй ажиллахад илүү хэцүү байдаг. Тиймээс хэрэглэгчдэд тохиромжтой ашиглах хэлбэрийн сонголттой байвал зохино.

Нээлттэй стандарт нь ЭӨ-ийн өгөгдлийн ангилалд бүхэлдээ хэрэглэгдэх боломжтой. ЭӨӨС нь эцсийн өмчлөлийн мэдээллийг тодорхой загвараар нийтлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог (Нүд 9-н харна уу). Нээлттэй стандартыг ашигласнаар бусад багц өгөгдөлтэй өндөр түвшинд харилцан ажиллах боломжтой болох бөгөөд хэрэглэгчдэд өгөгдлийг одоо байгаа систем, хэрэгсэл, үйл ажиллагааны механизмд нэгтгэх боломж олгоно.⁷¹

Эцэст нь, нээлттэй стандарт нь бие даасан өгөгдлийн талбарт хэрэглэгдэхээс гадна, тодорхой өгөгдлийн талбаруудын хэлбэрийг сонгоход мөн хэрэглэгдэж болно. Жишээ нь, огноог ISO 8601 гэх мэт тохиролцсон, баримтжуулсан стандартын дагуу хэлбэржүүлэх ёстой.⁷² Компанийн таних тэмдгийг мөн стандартаар хоёрдмол утгыг нь арилгаж болно. Үүнийг хийх хэд хэдэн арга бий. Жишээ нь, org-id.guide нь бүртгэлийн таних тэмдэгтэй орон нутгийн компанийн дугаарын өмнө байдаг.⁷³ LEI нь орон нутгийн компанийн дугаараас гадна өгөгдсөн онцгой таних тэмдэг юм.⁷⁴

Нүд 9: Эцсийн өмчлөлийн өгөгдлийн стандарт⁷⁵

ЭӨӨС нь ангилсан өгөгдлийн хэлбэрийн хамтаар эцсийн өмчлөлийн өгөгдлийг цуглуулах, хуваалцах, ашиглах удирдамжаар хангана. ОО нь үүнийг Open Data Services-тэй хамтран боловсруулсан.⁷⁶

Өгөгдлийн схем нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчдийн өгөгдлийг хэрхэн ангилж, хуваалцаж болохыг тайлбарлана. Уг схемийг JSON ангилсан өгөгдлийн форматаар тодорхойлсон.⁷⁷ Уг форматыг ашиглах нь компьютержсэн нэвтрэх эрх, дүн шинжилгээ хийх боломжийг хялбаршуулахаас гадна өгөгдлийг хүн унших боломжтой болгодог. Уг схемийг мөн өгөгдөл цуглуулах, удирдах системийг бүтээхэд мэдээлэл өгөх зориулалтаар ашиглаж болох ба дагалдах техникийн зааварчилгаа нь өгөгдөл нийтлэгчид болон хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

ЭӨӨС нь сайн тодорхойлогдсон, бас уян хатан юм. Эцсийн өмчлөлийн үндэсний бүртгэл, мөн компанийн бүтцийг судалж, тайлбарлаж буй хүмүүс үүнийг ашиглаж болно. Үндэстэн дамнасан өмчлөлийн бүтцийг зураглахын тулд, ЭӨӨС-д нийтлэгдсэн өөр өөр улс орнуудын өгөгдлийг хялбархан нэгтгэж болно.

Уг танилцуулгыг бичиж байх үеийн байдлаар, ЭӨӨС-ын 0.3 хувилбар гарсан байсан бөгөөд Армени, Латви, Нигери улсад хэрэгжүүлж байна.⁷⁸ Их Британийн Өгөгдлийн стандартын газар нь засгийн газраас ЭӨ-ийн өгөгдлийг цуглуулах, солилцох, ашиглах, түгээх зорилгоор ЭӨӨС-ыг ашиглахыг зөвшөөрсөн.⁷⁹ Түүнчлэн, хувийн хэвшлийн бүртгэлийн програм хангамж үйлдвэрлэгчид ЭӨӨС-ыг бүтээгдэхүүндээ шууд суулгаж, улс дотроо нэвтрүүлж эхэлсэн.⁸⁰



Нийтлэгдсэн өгөгдлийг аудит хийх боломжтой байлгах

Хэрэгжүүлэгчид нийтлэгдсэн өгөгдлийг аудит хийх боломжтой байлгаж, **өгөгдөлд нэвтрэх олон аргаар хангах замаар** нэвтрэх, тайлбарлах, ашиглахад хялбар байлгах боломжтой.^h Өөр өөр хэрэглэгчид ижил өгөгдөлд харилцан адилгүй аргаар нэвтрэх шаардлагатай бөгөөд өөр өөр хэрэглээний тохиолдлуудад харилцан адилгүй аргаар өгөгдөлд нэвтрэх шаардлагатай болдог. Өгөгдөл нь техникийн бус хэрэглэгчид, техникийн хэрэглэгчид болон системүүдийн аль алинд нь тохирсон форматтай байх ёстой. Энэ нь нийтлэгчид өгөгдөлд нэвтрэх олон арга хэлбэрээр хангах ёстой гэсэн үг юм. Үүнд дараахыг оруулах ёстой. Эдгээр нь:

- Вэб интерфэйсээр дамжуулан бүртгэлээр хайх. Хайлт нь ЭӨ-ийн өгөгдөлд нэвтрэх хамгийн шилдэг арга юм. Компанийн өгөгдлийг урьдчилан мэдэх нь ховор байдаг тул, хайлт нь аль болох уян хатан байх ёстой бөгөөд энгийн хэрэглэгчдэд хүртээмжтэй байх ёстой гэдгийг анхаарах хэрэгтэй. Үүний нэг жишээ нь, хайлтын лавлагаанд хэсэгчлэн тохирох боломж олгодог Их Британийн СН хайлт юм. Өгөгдлийг компани болон эцсийн өмчлөгчөөр нь хайх боломжтой байх ёстой.⁸¹
- Вэб интерфэйсээр дамжуулан бүртгэлийг үзнэ. Ангилсан өгөгдөл нь хүмүүс болон компаниудын хоорондын шууд мэдэгдэхгүй холболтыг илрүүлэх боломжийг олгодог. Жишээ нь, ОО-ын бүртгэлд интерфэйс нь компанийн эцсийн өмчлөгчдийг харуулна. Тусдаа эцсийн өмчлөгч дээр дарснаар, ЭӨ-тэй холбоотой бусад бүх хуулийн этгээдийг харуулна.
- Бөөнд нь боловсруулах хэлбэр. Багц өгөгдөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийхэд бүртгэлийг бөөнөөр нь ачаалах замаар бүх бүртгэлд нэвтрэх шаардлагатай болдог. Үүнийг эх сурвалжийн системээс ердийн экспорт хийх замаар хангаж болно.ⁱ Жишээ нь, Украины Хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчид, олон нийтийн байгууллагуудын улсын нэгдсэн бүртгэлийн өгөгдөл нээлттэй бөгөөд өдөр бүр нээлттэй файл хэлбэрээр бөөнөөр нь татаж авах боломжтой.⁸²

- API-ээр дамжуулан нэвтрэх. API нь хоёр програм хангамжийг хоорондоо харилцах боломжтой болгодог интерфэйс юм. Аливаа програмын дүн шинжилгээ эсвэл ЭӨ-ийн өгөгдлийн нэг төхөөрөмжөөс нөгөө төхөөрөмж хоорондын хэрэглээ нь интернэтээр мэдээлэл авах ангилсан хүсэлт гаргах арга болох Web API-г тулгуурласан байх магадлалтай. API-ийн ачаалал ихтэй хэрэглээг арилжааны гэрээгээр дамжуулан хэрхэн зохицуулахыг харгалзаж үзэх хэрэгтэй. Их Британийн ЭӨ-ийн бүртгэлийг хэрэгжүүлсний дараах үнэлгээгээр API хандалт болон бөөнөөр хийх нэвтрэлт нь хэрэглэгчдэд хамгийн их үнэ цэнийг бий болгодог гэж дурдсан байна.⁸³

Өгөгдөлд нэвтрэх эдгээр арга тус бүрийн хувьд, өгөгдлийн эцсийн өмчлөлийн өөрчлөлтийн түүхэн бүртгэлд нэвтрэх боломжийг олгох замаар бүртгэлд аудит хийх боломжтой байх ёстой.

Өгөгдлийг найдвартай ашиглахын тулд, энэ нь **лицензтэй** байх ёстой. Нээлттэй тодорхойлолтыг ашиглах нь өгөгдлийн хэрэглээг хялбаршуулах боломжтой хэдий ч, лиценз олгох шийдвэрийг тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохируулан гаргах ёстой.⁸⁴ Дотоодын өгөгдлийн хамгаалалт, нууцлалын хуулиудыг авч үзэх шаардлагатай бөгөөд лиценз олгох шийдвэрт нөлөөлж болзошгүй. Мэдээллийг ил тод болгох дэглэмтэй олон улс орны хувьд, лиценз олголтынхоо талаар мэдээлэл өгдөггүй нь өгөгдөл ашиглах итгэлийг алдагдуулж байна. Дани, Латви, Нигери, Их Британи, Украин зэрэг хэд хэдэн улс орнууд ЭӨ-ийн мэдээллийг нээлттэй өгөгдөл хэлбэрээр нийтэлдэг.⁸⁵

Эцэст нь, өгөгдлийг хэрэгцээтэй байлгахын тулд, шаардлагатай **холбогдох нөхцөл байдал, баримт бичгийг** нь дагалдуулах ёстой. Нийтлэлийн бодлого буюу өгөгдөл ашиглалтын гарын авлага нь ЭӨ-ийн өгөгдлийн дахин ашиглалтыг нөхцөл байдалтай нь уялдуулан тайлбарлах, ойлгох, төлөвлөх боломжийг хэрэглэгчдэд олгодог. Нийтлэлийн бодлогод лиценз олгох талаарх нарийвчилсан мэдээлэл; холбогдох хууль тогтоомж руу нэвтрэх холбоос; өгөгдлийг цаг тухайд нь нийтлэх бодлого; хэрэглэгчдэд түүхэн цуврал өгөгдлийн тасалдлыг ойлгох боломж олгох зориулалттай өгөгдлийн чухал өөрчлөлтүүдийн бүртгэл (техникийн эсвэл хууль, дүрмийн өөрчлөлтийн хариуд) зэрэг мэдээлэл

^h Энд тоймлосон өгөгдөлд нэвтрэх аргууд нь бүх хэлбэрээр нийтэд нээлттэй биш байлаа ч гэсэн, дотоодын засгийн газрын хэрэглэгчдэд мөн хэрэглэгдэнэ. Жишээ нь, хэд хэдэн улс орнууд үүнийг баримтжуулсан асуудалгүйгээр хийсэн хэдий ч, зарим засгийн газар нууцлалын шалтгаанаар өгөгдлийг бөөнд нь ил тод болгохгүй байж болно. Энэ тохиолдолд, хууль сахиулах байгууллагад идэвхтэй шалгалт явуулахын тулд өгөгдлийг бөөнд нь ил тод болгох ёстой.

ⁱ Өөр нэг арга нь хэрэглэгчдэд нийтлэгчийн API-г оруулсан өөрчлөлтийн урсгалаас багц өгөгдлийн одоогийн (эсвэл дурын) төлөвийг үүсгэх боломж олгодог урсгалын API-г нэвтрэх боломж олгох юм. Энэ нь илүү уян хатан, хүчирхэг бөгөөд урт хугацаанд том ЭӨ-ийн багц өгөгдөлд илүү тохиромжтой байж болох хэдий ч, ашиглах, хэрэгжүүлэхэд илүү төвөгтэй байдаг.



агуулагдаж болно. Өгөгдөл хэрэглэгчийн гарын авлага нь ЭӨ-ийн өгөгдөлд нэвтрэх, дүн шинжилгээ хийх, ашиглахад шаардлагатай мэдээллээр хэрэглэгчдийг хангах ёстой. Үүнд албан ёсны баримт бичиг, албан ёсны бус гарын авлага, заавар зэрэг зүйлс орж болно.

Дүгнэлт

ЭӨИТБ-ын шинэчлэлийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд, мэдээлэл ил болгох дүрмээр ЭӨИТБ-ын мэдээллийг ангилсан өгөгдөл хэлбэрээр цуглуулж, хадгалж, нийтлэх ёстой. Энэхүү товч танилцуулга нь хэрэгжүүлэлтийн эдгээр техникийн хандлагуудын бодлогын үр ашиг, давуу талуудыг онцолсон. Энэ нь өгөгдлийг үр ашигтай цуглуулах, хадгалах, хэвлэн нийтлэх, ашиглахад дэмжлэг үзүүлэх систем, технологийг хэрэгжүүлэхийн тулд, бодлогын түвшинд юу хийх ёстой талаарх анхаарах зүйлсийг хэрэгжүүлэгчдэд сануулна.

Дүгнэж хэлэхэд, өгөгдлийг ангилснаар урьдчилан таамаглах боломжтой мэдээллийг бий болгож, ажиллахад хялбар болгож, ашиглалтыг нь сайжруулна. Эдгээр ашиг тус нь техникийн болон техникийн бус хэрэглэгчдэд аль алинд нь хамаарна. Ангилаагүй өгөгдөлтэй холбоотой зарим саад бэрхшээлийг арилгаснаар, ангилсан өгөгдөл нь дараах зардлыг бууруулна. Эдгээр нь: засгийн газруудад өгөгдөл цуглуулах; хуулийн этгээдийн ил тод зарлах шаардлагыг дагаж мөрдөх; өгөгдлийг хадгалах, нийтлэх, ашиглах; бодлогын үр ашгийг бодит болгох. Энэ нь эцсийн дүндээ, ЭӨИТБ-ын шинэчлэлийн бодлогын нөлөөллийг нэмэгдүүлэхэд мөн нэмэр болно. Шаардлагатай системийг бий болгохтой холбоотой өндөр өртөг зардлыг урт хугацаанд цуглуулах, хадгалах, нийтлэх, ашиглах, засварлахтай холбоотой бага зардлаар нөхнө гэж үзэж байгаа.

ЭӨ-ийн ангилсан өгөгдөл дээр харилцан ажиллах боломжтой тул, бодлогын нөлөө нь их байдаг. Эцсийн өмчлөлийн мөн чанарыг хамгийн их үнэ цэнэтэй байлгахын тулд, үүнийг бусад эцсийн өмчлөл болон ЭӨ-ийн бус багц өгөгдөлтэй нэгтгэх ёстой гэсэн үг юм. Ангилсан өгөгдөл нь цуглуулах, баталгаажуулах зэрэг мэдээллийг ил тод болгох бусад хандлагуудыг хялбаршуулдаг. ЭӨӨС нь харилцан ажиллах боломжид голчлон тулгуурлаж бүтээгдсэн.

ЭӨ-ийн ангилсан өгөгдлийг ашиглахын тулд хэрэгжүүлэгчид хууль эрх зүйн болон бодлогын таатай орчныг бүрдүүлэх; хангалттай нөөцөөр хангах; мөн хэрэглэгч төвтэй, давтагдах аргыг ашиглах ёстой. Өгөгдлийн

ангилал нь хүн, хуулийн этгээд болон бусад холбогдох талуудыг онцгой, байнгын, шийдвэрлэх боломжтой таних тэмдэг ба бусад тодорхойлох өгөгдлийн талбараар дамжуулан таних чадвартай байх ёстой. Энэхүү ангилал нь өмчлөл, хяналтын харилцааг хангалттай, нарийвчлан ангилах замаар тайлбарлах чадвартай байх ёстой. Аудит хийх боломжтой, харилцан ажиллах боломжтой байлгахын тулд, нэмэлт цаг хугацааны өгөгдөл болон мета өгөгдлийг цуглуулах ёстой. Техникийн систем, бизнесийн үйл ажиллагаа, өгөгдлийн сангийн загвар нь өгөгдлийг нийтлэх, хуваалцахаас хүлээгдэж буй бүрэн ажиллагаа, нэвтрэх боломжийг хангаж байх ёстой бөгөөд үүнийг эхний үе шатнаас зохих ёсоор анхаарах хэрэгтэй. Эцэст нь, янз бүрийн аргаар мэдээллээр хангах, зохих лицензийг сонгох, лицензийн мэдээллийг нэмэлт баримт бичиг, өгөгдөл нийтлэх бодлогын хамтаар нийтлэх замаар өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлэх боломжтой.

Улам олон улс орнууд ЭӨӨС-ыг оруулаад ангилсан ЭӨ-ийн өгөгдлийг нийтэлж эхэлж байгаа нь нөхцөл байдлаас хамаарсан харилцан ажиллах боломж, өгөгдлийн хэрэглээ, үнэ цэнийг нэмэгдүүлж байна. Илүү их өгөгдлийг ашиглах боломжтой болохын хэрээр, тухайн мэдээллийг ОО-ын бүртгэлд оруулах ба ОО нь янз бүрийн ашиглалтын тохиолдол, нөлөөллийг баримтжуулсаар байх болно.

Нэмэлт тайлбар

- # Нэмэлт тайлбар
- 1 Жишээг эндээс харна уу: “Case studies”, Open Ownership, n.d., <https://www.openownership.org/en/publication-categories/case-studies>.
 - 2 Үүнийг харна уу: “Beneficial Ownership Data Standard”, Open Ownership, n.d., <https://www.openownership.org/en/topics/beneficial-ownership-data-standard>.
 - 3 “Open Ownership Principles – Structured data”, Open Ownership, updated July 2021, <https://www.openownership.org/en/principles/structured-data>.
 - 4 FAIR зарчим нь өгөгдлийн удирдлага, төхөөрөмжөөр боловсруулах боломжтой өгөгдлийг удирдах тогтолцоог санал болгодог. Үүнийг харна уу: “FAIR Principles”, GO FAIR, n.d., <https://www.go-fair.org/fair-principles>.
 - 5 “Beneficial Ownership Data Standard (v0.3)”, Open Ownership.
 - 6 “The companies we keep: What the UK’s open data register actually tells us about company ownership”, Global Witness, n.d., <https://www.globalwitness.org/en/campaigns/corruption-and-money-laundering/anonymous-company-owners/companies-we-keep>.
 - 7 “Learning the lessons from the UK’s public beneficial ownership register”, Global Witness and Open Ownership, November 2017, 8, <https://www.openownership.org/en/publications/learning-the-lessons-from-the-uks-public-beneficial-ownership-register>.
 - 8 “Learning the lessons from the UK’s public beneficial ownership register”, Global Witness and Open Ownership, 8.
 - 9 Ben Cowdock, “Tackling abuse of the Scottish Limited Partnerships needs a UK-wide money laundering reform”, Transparency International UK, 3 May 2018, <https://www.transparency.org.uk/tackling-abuse-scottish-limited-partnerships-needs-uk-wide-money-laundering-reform>.
 - 10 Жишээ нь, үүнийг харна уу: David Leask and Richard Smith, “Scots shell companies used to launder £4 billion out of Russia”, The Herald, 27 March 2017, <https://www.heraldsotland.com/news/15183346.scots-shell-companies-used-to-launder-4-billion-out-of-russia/>; Jacsy Gascoyne, “The Use of Scottish Limited Partnerships in Money laundering Schemes”, MLROs.com, n.d., <https://mlros.com/the-use-of-scottish-limited-partnerships-in-money-laundering-schemes/>.
 - 11 Chinwe Ekene Ezeigbo, Tymon Kiepe, and Louise Russell-Prywata, “Early impacts of public registers of beneficial ownership: United Kingdom”, Open Ownership, 1 April 2021, <https://www.openownership.org/en/publications/early-impacts-of-public-registers-of-beneficial-ownership-uk/>.
 - 12 Кейс судалгааг бүтнээр нь үзэхийг хүсвэл, үүнийг харна уу: Alanna Markle, “Early impacts of public beneficial ownership registers: Ukraine”, Open Ownership, 1 February 2022, <https://www.openownership.org/en/publications/early-impacts-of-public-beneficial-ownership-registers-ukraine>.
 - 13 YouControl, “About us”, n.d., https://youcontrol.com.ua/en/about_us/#about-system.
 - 14 Үүнийг харна уу: YouControl, “Case Studies”, n.d., <https://youcontrol.com.ua/en/cases/>.
 - 15 “ISO 8601 – Date and time format”, International Organization for Standardization, n.d., <https://www.iso.org/iso-8601-date-and-time-format.html>.
 - 16 ЭӨИТБ-ын систем, бизнесийн үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл: “Guide to implementing beneficial ownership transparency”, Open Ownership, July 2021, 13, <https://www.openownership.org/en/publications/guide-to-implementing-beneficial-ownership-transparency/>.
 - 17 Juraj Labant and Gabriel Šipoš, “The Register of Beneficial Ownership in Slovakia: Revolutionary transparency, questionable implementation, unsure benefits”, Transparency International Slovakia, June 2017, http://transparency.sk/wp-content/uploads/2017/06/Register-of-beneficial-ownership_study2017.pdf.
 - 18 “Impact Assessment study on the list of High Value Datasets to be made available by the Member States under the Open Data Directive”, Deloitte, EC Directorate-General for Communications Networks, Content and Technology, 30 December 2020, 128, <https://doi.org/10.2759/493091>.
 - 19 “Valuing the user benefits of Companies House data – Report 2: Direct Users”, BEIS, Research Paper Number 2019/015, September 2019, 24, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/833767/valuing-benefits-companies-house-data-report-2-direct-users.pdf. ЭӨИТБ-ын шинэчлэлийн эдийн засгийн үр ашгийг хэмжих талаарх нэмэлт мэдээллийг эндээс харна уу: “Measuring the economic impact of beneficial ownership transparency”, Lateral Economics, Open Ownership, and Oxford Insights, May 2022, <https://www.openownership.org/en/publications/measuring-the-economic-impact-of-beneficial-ownership-transparency-summary-report/>.
 - 20 “B.C. Consultation on a Public Beneficial Ownership Registry”, Province of British Columbia, Ministry of Finance, January 2020, 12, <https://engage.gov.bc.ca/app/uploads/sites/121/2020/01/386142-BCABO-Consultation-Documents-For-Release.pdf>.
 - 21 Paul May, “The use of beneficial ownership data by a financial service institution”, Open Ownership, Unpublished.
 - 22 ЭӨИТБ-ын эдийн засгийн үр ашгийг хэмжих талаарх нэмэлт мэдээллийг эндээс харна уу: “Measuring the economic impact of beneficial ownership transparency”, Lateral Economics et al.
 - 23 Tymon Kiepe, “Making central beneficial ownership registers public”, Open Ownership, 4, <https://www.openownership.org/en/publications/making-central-beneficial-ownership-registers-public>.
 - 24 “openownership/visualisation-tool: A visualisation library for beneficial ownership structures”, GitHub, n.d., <https://github.com/openownership/visualisation-tool>.
 - 25 Steve Day, “Transforming procurement systems, one prototype at a time”, Open Ownership, 18 December 2020, <https://www.openownership.org/blogs/tps-prototyping>.
 - 26 “Armenia and Latvia become first countries to publish data in line with the Beneficial Ownership Data Standard”, Open Ownership, 15 September 2021, <https://www.openownership.org/en/blog/armenia-and-latvia-become-first-countries-to-publish-data-in-line-with-the-beneficial-ownership-data-standard>.
 - 27 “openownership/visualisation-tool”, GitHub.
 - 28 “Sagamar CJSC – Electronic Register”, Government of Armenia, 2018, <https://www.e-register.am/am/companies/1267708/beneficiary.pdf>; “BOR declarations: «ՋԱՆԳԵՏՊԻՊԻ ՊՊՆԱՍՏԻՊԻՊԵՆԱՅԻՆ ԿՈՄՊԻՆԱՏ» փրթը – Electronic Register”, Government of Armenia, 25 June 2021, <https://www.e-register.am/en/companies/1340197/declaration/c51e08a7-6fdb-4ab7-a55c-c74a68a8f54c?diagram=1>.
 - 29 Нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: Day, “Transforming procurement systems, one prototype at a time”. Худалдан авалт хийхдээ ЭӨ-ийн өгөгдлийг ашиглах талаарх нэмэлт мэдээллийг эндээс харна уу: Tymon Kiepe and Eva Okunbor, “Beneficial ownership data in procurement”, Open Ownership, 11 March 2021, www.openownership.org/en/publications/beneficial-ownership-data-in-procurement.



- 30 "org-id.guide – list locator (Alpha)", org-id.guide, n.d., <https://org-id.guide/about>.
- 31 Үүнийг харна уу: "Common Reporting Standard (CRS)", OECD, n.d., <https://www.oecd.org/tax/automatic-exchange/common-reporting-standard/>.
- 32 Баталгаажуулах янз бүрийн аргуудын хувьд, ангилсан өгөгдөл хэрхэн тусалж болох талаарх нэмэлт мэдээллийг эндээс харна уу: Tymon Kiepe, "Verification of beneficial ownership data", Open Ownership, 7 May 2020, <https://www.openownership.org/en/publications/verification-of-beneficial-ownership-data>.
- 33 Emile van der Does de Willebois, Emily M. Halter, Robert A. Harrison, Ji Won Park, and J.C. Sharman, The Puppet Masters: How the Corrupt Use Legal Structures to Hide Stolen Assets and What to Do About It (Washington DC: The World Bank, 2011), 52, 121, <https://star.worldbank.org/sites/star/files/puppetmastersv1.pdf>.
- 34 Van der Does de Willebois et al., The Puppet Masters: How the Corrupt Use Legal Structures to Hide Stolen Assets and What to Do About It, 9.
- 35 "Beneficial ownership information", Open Contracting Data Standard, n.d., https://standard.open-contracting.org/latest/en/guidance/map/beneficial_ownership.
- 36 Tymon Kiepe, "Using beneficial ownership data for national security", Open Ownership, 17 December 2021, 18-19, <https://www.openownership.org/en/publications/using-beneficial-ownership-data-for-national-security>.
- 37 Steve Day, "Reconciling beneficial ownership data", Open Ownership, 17 August 2020, <https://www.openownership.org/blogs/reconciling-beneficial-ownership-data>; Jason Arterburn, Erin D. Dumbacher, and Page O. Stoutland, "Signals in the Noise: Preventing Nuclear Proliferation with Machine Learning & Publicly Available Information", Nuclear Threat Initiative and Center for Advanced Defense Studies, 12 January 2021, <https://www.nti.org/analysis/reports/signals-in-the-noise>.
- 38 "Revised Guidance on Entities Owned by Persons Whose Property and Interests in Property Are Blocked", US Department of the Treasury, 13 August 2014, https://home.treasury.gov/system/files/126/licensing_guidance.pdf.
- 39 "About this project", OpenSanctions, n.d., <https://www.opensanctions.org/docs/about>.
- 40 "Identifiers and de-duplication", OpenSanctions, n.d., <https://www.opensanctions.org/docs/identifiers>.
- 41 "How we deduplicate companies and people across data sources", OpenSanctions, 11 November 2021, <https://www.opensanctions.org/articles/2021-11-11-deduplication/>.
- 42 "Global LEI Index", Global Legal Entity Identifier Foundation, n.d., <https://www.gleif.org/en/lei-data/global-lei-index>.
- 43 "Level 2 Data: Who Owns Whom", Global Legal Entity Identifier Foundation, n.d., <https://www.gleif.org/en/lei-data/access-and-use-lei-data/level-2-data-who-owns-whom>.
- 44 "Legal Entity Identifier (LEI) Reference Data", OpenSanctions, n.d., <https://www.opensanctions.org/datasets/gleif/>.
- 45 "opensanctions/icij-offshoreleaks: Converter for ICIJ Offshore Leaks data into FollowTheMoney format used by OpenSanctions", GitHub, n.d., <https://github.com/opensanctions/icij-offshoreleaks>.
- 46 "OpenScreening", Linkurious, n.d., <https://resources.linkurious.com/openscreening>; "opensanctions/offshore-graph: Loading OpenSanctions into Neo4J and Linkurious", GitHub, n.d., <https://github.com/opensanctions/offshore-graph>.
- 47 Уг танилцуулгыг бичиж байх үеийн байдлаар, ОО нь ОО-ын бүртгэлийн ЭӨ-ийн өгөгдлийг энэ төсөлд оруулахаар OpenSanctions багтай хамтран ажиллаж байна.
- 48 Open Ownership, "Open Ownership technology showcase #4", YouTube video, 1:03:14, posted 18 May 2022, <https://www.youtube.com/watch?v=ipKkRX8vpZg>.
- 49 Gregor Semieniuk et al., "Stranded fossil-fuel assets translate to major losses for investors in advanced economies", Nature Climate Change 12, (26 May 2022): 532-538, <https://doi.org/10.1038/s41558-022-01356-y>.
- 50 Баталгаажуулалтаар дамжуулан найдвартай ЭӨ-ийн өгөгдлийг үүсгэх талаарх нэмэлт мэдээллийг эндээс харна уу: Kiepe, "Verification of beneficial ownership data".
- 51 Thom Townsend, "Effective consultation processes for beneficial ownership transparency reform", Open Ownership, 20 June 2020, 12, <https://www.openownership.org/en/publications/effective-consultation-processes-for-beneficial-ownership-transparency-reform>.
- 52 "Open Ownership Principles", Open Ownership.
- 53 Нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: Ramandeep Kaur Chhina and Tymon Kiepe, "Designing sanctions and their enforcement for beneficial ownership disclosure", Open Ownership, 28 April 2022, <https://www.openownership.org/en/publications/designing-sanctions-and-their-enforcement-for-beneficial-ownership-disclosure>.
- 54 Шаталсан нэвтрэх эрх болон хамгаалалтын дүрмийг хэрэгжүүлэх талаарх нэмэлт мэдээллийг эндээс харна уу: Kiepe, "Making central beneficial ownership registers public", 17-19.
- 55 Үүнийг харна уу: "How to make a business case for open data", Open Data Institute, 20 October 2013, <https://theodi.org/article/how-to-make-a-business-case-for-open-data>; "Research: The economic value of open versus paid data", Open Data Institute, 20 April 2016, <https://theodi.org/article/research-the-economic-value-of-open-versus-paid-data>; Kiepe, "Making central beneficial ownership registers public", 4. ЭӨИТБ-ын шинэчлэлийн эдийн засгийн үр ашгийг хэмжих аргачлалыг эндээс харна уу: "Measuring the economic impact of beneficial ownership transparency", Lateral Economics et al.
- 56 "Why do open organisational identifiers matter?", Open Data Services, Medium, 13 April 2022, <https://medium.com/opendatacoop/why-do-open-organisational-identifiers-matter-46af05ab30a>; Deborah Yates, "Sustainable stewardship of open identifiers", Open Data Institute, 7 September 2021, <https://theodi.org/article/sustainable-stewardship-of-open-identifiers>.
- 57 "Real world identifiers", Open Ownership, n.d., <https://standard.openownership.org/en/latest/schema/guidance/identifiers.html>.
- 58 "Fact Sheet: Beneficial Ownership Information Reporting Notice of Proposed Rulemaking (NPRM)", Financial Crimes Enforcement Network, US Treasury, 7 December 2021, <https://www.fincen.gov/news/news-releases/fact-sheet-beneficial-ownership-information-reporting-notice-proposed-rulemaking>.
- 59 Жишээ нь, Их Британийн Хууль зүйн яамны өгөгдлийн сан дахь магадлалын бүртгэлийн холбоосыг ашиглаж, давхардлыг нь арилгаж харна уу: "moj-analytical-services/splink: Fast, accurate and scalable probabilistic data linkage using your choice of SQL backend", GitHub, n.d., <https://github.com/moj-analytical-services/splink>. Их Британийн Өрсөлдөөн, зах зээлийн газар бүртгэлийг холбох, Их Британийн ЭӨ-ийн өгөгдөлд онцгой таних тэмдгийг хуваарилахад үүнийг ашигласан. Эндээс харна уу: Open Ownership, "Open Ownership technology showcase #4".



- 60 Шаталсан нэвтрэх эрхийн талаарх нэмэлт мэдээллийг эндээс харна уу: Kiepe, "Making central beneficial ownership registers public", 17.
- 61 Үүнийг харна уу: "Open Ownership Principles – Sufficient detail", Open Ownership, updated July 2021, <https://www.openownership.org/en/principles/sufficient-detail>; "Beneficial ownership declaration forms: Guide for regulators and designers", Open Ownership, 17 March 2021, <https://www.openownership.org/en/publications/beneficial-ownership-declaration-forms-guide-for-regulators-and-designers>.
- 62 Lubumbe Van de Velde, "Gender and beneficial ownership transparency", Open Ownership, 28 April 2022, <https://www.openownership.org/en/publications/gender-and-beneficial-ownership-transparency>.
- 63 Нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: Kadie Armstrong, "Building an auditable record of beneficial ownership", Open Ownership, forthcoming.
- 64 Үүнийг харна уу: "Open Ownership Principles – Up to date and auditable", Open Ownership, updated July 2021, <https://www.openownership.org/en/principles/up-to-date-and-auditable>.
- 65 Үүнийг харна уу: Kiepe, "Making central beneficial ownership registers public", 19.
- 66 Kadie Armstrong and Jack Lord, "Beneficial ownership transparency and listed companies", Open Ownership, 17 September 2020, <https://www.openownership.org/en/publications/beneficial-ownership-transparency-and-listed-companies>; "Open Ownership Principles – Comprehensive coverage", Open Ownership, updated July 2021, <https://www.openownership.org/en/principles/comprehensive-coverage>.
- 67 Нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: "Beneficial ownership declaration forms", Open Ownership.
- 68 Нэмэлт мэдээлэл болон техникийн нарийвчилсан зааварчилгааг эндээс харна уу: "Relational database design considerations for beneficial ownership information", Extractive Industries Transparency Initiative and Open Ownership.
- 69 Мэдээлэл ил болгох цар хүрээ, хянах хэлбэрийн талаарх техникийн зааварчилгаа, эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар нэмэлт мэдээллийг эндээс харна уу: "Beneficial ownership declaration forms", Open Ownership.
- 70 Kiepe, "Making central beneficial ownership registers public".
- 71 "Beneficial Ownership Data Standard (v0.3)", Open Ownership.
- 72 "ISO 8601 – Date and time format", International Organization for Standardization.
- 73 "org-id.guide - list locator (Alpha)", org-id.guide.
- 74 "Global LEI Index", Global Legal Entity Identifier Foundation.
- 75 "Beneficial Ownership Data Standard (v0.3)", Open Ownership.
- 76 "We help people publish and use open data", Open Data Services, n.d., <https://opendataservices.coop>.
- 77 "Beneficial Ownership Data Standard – Schema browser", Open Ownership, n.d., <https://standard.openownership.org/en/0.3.0/schema/schema-browser.html>.
- 78 Stephen Abbott Pugh, "Launch of version 0.3 of the Beneficial Ownership Data Standard", Open Ownership, 20 June 2022, <https://www.openownership.org/en/news/launch-of-version-03-of-the-beneficial-ownership-data-standard>.
- 79 "Collect, use and exchange beneficial ownership information", UK Cabinet Office, updated 16 March 2022, <https://www.gov.uk/government/publications/open-standards-for-government/collect-use-and-exchange-beneficial-ownership-information>.
- 80 Жишээ нь, үүнийг харна уу: "Beneficial Ownership Register", Foster Moore, n.d., <https://www.fostermoore.com/verne/beneficial-ownership-register>.
- 81 Үүнийг харна уу: "Open Ownership Principles – Public access", Open Ownership, updated July 2021, <https://www.openownership.org/en/principles/public-access>.
- 82 "Ukraine Consolidated State Registry (Edinyi Derzhavnyi Reestr [EDR])", Open Ownership, n.d., https://register.openownership.org/data_sources/ua-edr-register. 2022 оны 2-р сард Оросууд Украин руу довтолсноос хойш Украины ЭӨ-ийн бүртгэл офлайн байна.
- 83 "Valuing the user benefits of Companies House data – Report 2: Direct Users", BEIS, 24. Нэмэлт мэдээлэл авах бол, үүнийг харна уу: "Measuring the economic impact of beneficial ownership transparency", Lateral Economics et al.
- 84 "The Open Definition", Open Knowledge Foundation, n.d., <https://opendefinition.org>. Үүнийг харна уу: Kiepe, "Making central beneficial ownership registers public".
- 85 See indicator A.COMPANY.BOT.e.e3.LICENSE in "GDB full dataset", Global Data Barometer, 2021, <https://storage.googleapis.com/gdb-files/modules/gdb-2021-company-information-module-data.csv>. Жишээ нь, "Vilkår for brug af danske offentlige data", Erhvervsstyrelsen, 10 March 2015, https://hjaelp.virk.dk/sites/default/files/vilkaar_for_brug_af_danske_offentlige_data_v4.pdf; "Companies House public task and Crown copyright", UK Companies House, updated 9 August 2019, <https://www.gov.uk/government/publications/companies-house-accreditation-to-information-fair-traders-scheme>.

Зохиогчид

Jack Lord

Tymon Kiepe

хувь нэмэр оруулсан

Kadie Armstrong

Stephen Abbott Pugh

Редактор

Cara Marks

Хянасан

Christa Bull

Government of British Columbia

Jonathan Baron

Government of British Columbia

Silvana Fumega

Global Data Barometer

Орчуулагч

Alboun Translation Services

Загварыг гаргасан

Convincible Media

Нийтэлсэн

openownership.org

 @openownership

c/o Global Impact, 1199 North Fairfax Street, Suite 300, Alexandria, VA 22314, USA

**Open
Ownership**

